



GOBI 

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

**ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН
МАТЕРИАЛ**

2026 оны
4-р сарын 29-ний өдөр



Агуулга

- Хурлын зар4
- Хувьцаа эзэмшигчдийн танилцах боломжтой баримт бичгийн жагсаалт, хугацаа, арга хэлбэр.....5
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн хурлын тогтоол6
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр, дэг 8
- Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой материал
 - 1. Говь ХК-ийн 2025 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайлан10
 - 2025 оны санхүүгийн үр дүн10
 - Санхүүжилтийн мэдээлэл 16
 - Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл 17
 - Хувьцаа эзэмшигчид 21
 - Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд болон эцсийн өмчлөгчийн мэдээлэл 22
 - Дотоод зах зээл 23
 - Гадаад зах зээл 25
 - Программ хөгжүүлэлт, дижитал шилжилт 28
 - Үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн шинэ технологи, бүтээгдэхүүн хөгжүүлэлт 30
 - Нэгтгэсэн санхүүгийн тайлан 33
 - 2. 2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай 37
 - 3. ТУЗ-өөс Говь ХК-ийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагаа тайланд өгөх дүгнэлт 40
 - 4. ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлан 42
 - 5. ТУЗ-ийн 2026 оны цалингийн төсөв 55
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл 56
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн 58
- Санал авах хуудасны загвар 59



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2026 оны 3-р сарын 18-ны өдрийн №10 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг зарлаж байгаа тул хувьцаа эзэмшигч та бүхнийг оролцохыг урьж байна.

Хурлын өдөр:	2026 оны 4-р сарын 29-ний өдөр, Лхагва гараг
Эхлэх цаг:	14:00 цаг (Бүртгэл 13:00 цагт эхэлж 13:55 цагт хаагдахыг анхаарна уу)
Байршил:	ГОВЬ ХК (Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК-ийн өөрийн байр, 1-р давхар, Сургалтын танхим)
Хурлын хэлбэр:	Танхимаар
Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:	2026 оны 4-р сарын 8-ны өдөр
Хурлаар хэлэлцэх асуудал:	- Танилцуулах асуудал - Говь ХК-ийн 2025 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайланг танилцуулах 2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах - ТУЗ-ийн 2025 оны ажлын тайланг танилцуулах - Хэлэлцэн батлах асуудал - ТУЗ-өөс компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг батлах - ТУЗ-ийн 2026 оны цалингийн төсвийг батлах
Хурлын материалтай танилцах:	Хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2026 оны 3-р сарын 27-ны өдрөөс эхлэн дараах арга хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцаж болно. Үүнд: - Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас (open.mse.mn/securities/354); - Говь ХК-ийн цахим хуудас (info.gobi.mn); - Өөрийн харилцаж буй үнэт цаасны компаниасаа цахимаар болон биечлэн очиж; - Говь ХК-ийн оффисын байрны 4-р давхарт ажлын өдрүүдийн 09:00-17:00 цагийн хооронд ирж танилцах боломжтой.
Урьдчилан санал өгөх:	Хурлын материалтай танилцан, саналын хуудсыг бөглөж дараах арга хэлбэрээр 2026 оны 4-р сарын 24-ний өдрийн дотор иргэний үнэмлэх (хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ)-ний хуулбарын хамт ирүүлнэ үү: - Өөрийн харилцдаг үнэт цаасны компаниар дамжуулан өгөх; - Говь ХК дээр биечлэн ирж өгөх; - Шуудангаар илгээх (Говь ХК-ийн албан ёсны хаяг); - И-мэйлээр ирүүлэх (boardsecretary@gobicashmere.com).
Хурал зохион байгуулах комисстой холбоо барих:	Утас: 9411-8277 И-мэйл: boardsecretary@gobicashmere.com
Говь ХК-ийн албан ёсны хаяг:	Улаанбаатар - 17062, ХУД, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Утас: 7013-9977, Факс: 7014-3081, Шуудангийн хайрцаг: 36/434, Говь ХК



ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БОЛОМЖТОЙ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ, ХУГАЦАА, АРГА ХЭЛБЭР

- Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
 - Компанийн 2025 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайлан;
 - 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт;
 - ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал, бусад зардал;
 - ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлан, 2026 оны цалингийн төсөв;
 - Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн эсэх тухай хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт;
 - Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо;
 - Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл;
 - Хурлын санал авах хуудас;
 - Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой бусад мэдээлэл болон Компанийн тухай хуулийн 65.6-д заасан шаардлагатай бусад баримт бичиг.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь **2026 оны 3-р сарын 27-ны өдрөөс эхлэн** дараах арга хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
 - Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас (open.mse.mn/securities/354);
 - Говь ХК-ийн цахим хуудас (info.gobi.mn);
 - Өөрийн харилцаж буй үнэт цаасны компаниасаа цахимаар болон биечлэн очиж;
 - Говь ХК-ийн оффисын байрны 4-р давхарт ажлын өдрүүдийн 09:00-17:00 цагийн хооронд ирж танилцах боломжтой.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

GOBI



"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ
төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын ТОГТООЛ

2026 он 03 сар 18 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Говь ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид "Хурал" гэх)-ыг зарлан хуралдах асуудлыг хэлэлцэн, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60.1, 60.2, 60.4, 64.2, 65, 67, 71.1, 71.3, 76.1.2, 80.2 Компанийн дүрмийн 6.1.3, 6.1.4, 6.2.7.3, 6.2.7.4, 6.2.8 дугаар зүйл заалтуудыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Хурлын төв

- 1.1. Хурлыг 2026 оны 4-р сарын 29-ний Лхагва гарагийн 14:00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК-ийн өөрийн байр, 1-р давхар, Сургалтын танхимд **танхимын хэлбэрээр** хуралдуулсугай.

2. Хэлэлцэх асуудал, санал хураах журам

- 2.1. Хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтыг **Хавсралт 1-ээр** баталсугай.
- 2.2. Хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцах боломжтой баримт бичгийн жагсаалт, хугацаа, арга хэлбэрийг **Хавсралт 2-оор** баталсугай.
- 2.3. Санал авах хуудасны загварыг **Хавсралт 3-аар** баталсугай.
- 2.4. Санал хураалтыг хурлын үеэр авахаас гадна урьдчилсан байдлаар компанийн шуудангийн хаяг, и-мэйл хаяг болон үнэт цаасны компаниар дамжуулан хүлээн авах ба урьдчилан санал авах сүүлчийн өдрийг **2026 оны 4-р сарын 24-ний өдрөөр** тогтоосугай.

3. Бүртгэл, мэдээлэл хүргүүлэх

- 3.1. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2026 оны 4-р сарын 8-ны өдрөөр** тогтоосугай.
- 3.2. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид **2026 оны 3-р сарын 20-ны өдөр** хүргүүлж, хурлын зарыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын дагуу **2026 оны 3-р сарын 23 болон 4-р сарын 7-ны өдрүүдэд** олон нийтэд зарлахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (М.Сэлэнгэ)-д үүрэг болгосугай.
- 3.3. Хурлын зарын хэлэлцлийн эхийг **Хавсралт 4-өөр** баталсугай.

4. Хурлын баримт бичиг

- 4.1. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг **2026 оны 3-р сарын 27-ны өдрийн дотор** үнэт цаасны компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (М.Сэлэнгэ)-д үүрэг болгосугай.

"Говь" ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17062, Монгол улс
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, И-мэйл: info@gobi.mn, Вэб сайт: www.gobi.mn



GOBI



"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ
төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын ТОГТООЛ

2026 он 03 сар 18 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

5. Хурлын зохион байгуулалт

- 5.1. Хурлыг ТУЗ-ийн хараат бус гишүүн **Д.Гэрэлмаа** даргалсугай.
- 5.2. Хурлын хөтөлбөрийг **Хавсралт 5-аар** баталсугай.
- 5.3. Хурал зохион байгуулах комиссыг **Хавсралт 6-аар** томилсугай.
- 5.4. Хурлын Тооллогын комиссыг **Хавсралт 7-оор** томилсугай.
- 5.5. Хурлын бэлтгэлийг хангаж, хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичиг, мэдээллийг бэлдэх, хөтөлбөрийн дагуу зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комиссын даргад үүрэг болгосугай.
- 5.6. Хурлын ирцийг бүртгэж Хурлын даргад мэдээлэх, саналын хурааж, тооллогын үр дүнг нэгтгэн Хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Тооллогын комиссын даргад үүрэг болгосугай.

6. Хурлын шийдвэрийн хэрэгжилт

- 6.1. Хурлын шийдвэр болон бусад холбогдох баримт бичиг, тайлан мэдээллийг холбогдох хууль журамд заасан хугацаанд олон нийтэд мэдээлж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (М.Сэлэнгэ)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  Ц.БААТАРСАЙХАН

"Говь" ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17062, Монгол улс
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, И-мэйл: info@gobi.mn, Вэб сайт: www.gobi.mn



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх <i>Тооллогын комисс</i>	13:00-14:00
Хурлын ирцийг танилцуулах <i>Тооллогын комиссын дарга Б.Урангоо</i>	14:00-14:02
Хурлыг нээж, хурлын хөтөлбөрийг танилцуулах <i>Хурлын дарга Д.Гэрэлмаа</i>	14:02-14:05
Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина:	
4.1 Компанийн 2025 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайланг танилцуулах <i>Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан</i>	14:05-14:25
4.2 2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах <i>Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан</i>	14:25-14:30
4.3 ТУЗ-өөс компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах <i>ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа</i>	14:30-14:40
4.4 ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлан болон 2026 оны цалингийн төсвийг танилцуулах <i>ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа</i>	14:40-15:00
Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт <i>Хүн тус бүр 2 минут /Нийт 20 минут/</i>	15:00-15:20
Санал өгөх зааварчилгаа танилцуулах, санал авах <i>10 минут</i>	15:20-15:30
Завсарлага /Санал хураалтын дүнг нэгтгэх/ <i>20 минут</i>	15:30-15:50
Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах <i>Тооллогын комиссын дарга Б.Урангоо</i>	15:50-15:53
Хурлаас гарах тогтоолын төсөлд Тооллогын комиссын санал хураалтын дүнг тусган танилцуулж, тогтоолыг батлуулах <i>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ</i>	15:53-15:55
Хурлыг хаах <i>Хурлын дарга Д.Гэрэлмаа</i>	15:55-16:00

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг
Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг зохион байгуулах, асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд энэхүү дэгийг баримтална. Үүнд:


- Хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрээр томилогдсон эрх бүхий албан тушаалтан хурлыг удирдан явуулна.
- Хурлын ирцийг Тооллогын комисс танилцуулсны дараа Хурлын дарга хурлыг албан ёсоор нээнэ.
- Компанийн тухай хуульд заасны дагуу хурлаар хэлэлцэхээр урьдчилан тусгагдаагүй асуудлыг хэлэлцэхгүй.
- Хурлыг хөтөлбөрт заасан цагийн хуваарийн дагуу хуралдуулна.
- Хурлын явцад аливаа хэлбэрээр үймүүлэх, зориуд саатуулах, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдын нэр төрийг гутаах, гүтгэхийг хориглоно.
- Хурлын дэгийг зөрчсөн хувьцаа эзэмшигчид Хурлын дарга эхний удаа сануулга өгнө. Зөрчлийг давтан гаргасан тохиолдолд Хурлын даргын зөвшөөрлөөр Зохион байгуулах комисс тухайн хувьцаа эзэмшигчийг хурлаас гаргах арга хэмжээг авна.
- Хэлэлцэх асуудлуудтай холбоотой танилцуулга хийгдсэний дараа асуулт, хариултын ажиллагааг зохион байгуулна.
- Асуулт, хариулт дууссаны дараа санал хураалт явуулж, Тооллогын комисс саналын дүнг нэгтгэн, үр дүнг тусгасан тогтоол гаргаж, комиссын дарга уншиж танилцуулна.
- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Тооллогын комиссын тогтоолд үндэслэн хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулж, Хурлын даргаар баталгаажуулна.
- Хурлын дарга хурал хаасныг албан ёсоор мэдэгдэнэ.




1. ГОВЬ ХК-ИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮН

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, СЕГМЕНТЭЭР /тэрбум төгрөг, %/




БОРЛУУЛАЛТ. ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/




ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2007 ОНООС ХОЙШ НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
178.7 тэрбум төгрөг



2007 оны хувьчлалаас хойш өссөн дүнгээрээ нийт 178.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс 2019 онд 60 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 23 тэрбум нь Говь ХК-ийн барилга байгууламж, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгө оруулалтад зарцуулагдсан бол үлдсэн 37 тэрбум төгрөг нь Гоёо ХХК-г нэгтгэсний дүнд үүссэн өсөлт байв.

2025 оны хөрөнгө оруулалт




2025 онд нийт 2.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 36% буюу 0.8 тэрбум төгрөг нь биет бус хөрөнгө, 10% буюу 0.2 тэрбум төгрөг нь барилга байгууламж, 21% буюу 0.4 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмжид, 33% буюу 0.7 тэрбум төгрөгийг тавилга эд хогшил болон бусад хөрөнгө оруулалтад тус тус зарцуулсан байна.



ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ, ШИМТГЭЛ

Говь ХК нь 2007 оноос хойш зөвхөн Монголын татварын албанд нийт 304.1 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна. Үүнээс 2025 онд 34.1 тэрбум төгрөгийн татвар хураамж, шимтгэлийг улсын төсөвт төлсөн. Үүнийг нэр төрөл болон онуудаар дэлгэрүүлэн харуулав.




2025 ОНЫ САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ


ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2024 он	2025 он	Өөрчлөлт	
				тоо	хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	сая.төг	247,026	246,188	(839)	0%
Дотоод борлуулалт	сая.төг	163,359	199,275	35,916	22%
Экспортын борлуулалт	сая.төг	57,934	24,942	(32,993)	-57%
Гадаад борлуулалт	сая.төг	25,733	21,971	(3,762)	-15%
Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхэг	мян.ширхэг	1,055	970	(85)	-8%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	сая.төг	138,552	127,902	(10,650)	-8%
НИЙТ АШИГ	сая.төг	108,474	118,286	9,812	9%
Нийт ашгийн хувь	хувь	44%	48%	4%	9%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	81,395	59,800	(21,595)	-27%
Маркетингийн зардал	сая.төг	10,561	9,649	(912)	-9%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ	сая.төг	27,079	58,486	31,407	116%
Үйл ажиллагааны ашгийн хувь	хувь	11%	24%	13%	117%
Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	28,653	53,589	24,936	87%
Татварын өмнөх ашиг	сая.төг	(1,574)	4,897	6,471	411%
ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	сая.төг	(3,657)	203	3,861	106%
Цэвэр ашгийн хувь	хувь	-1%	0%	2%	106%
Нийт үйл ажиллагааны зардал	сая.төг	219,947	187,702	(32,245)	-15%
ҮЙЛДВЭРЛЭЛ	мян.ширхэг	1,005	882	(123)	-12%
Сүлжмэл бүтээгдэхүүн	мян.ширхэг	653	566	(87)	-13%
Нэхмэл бүтээгдэхүүн	мян.ширхэг	323	286	(37)	-12%
Оёмол бүтээгдэхүүн	мян.ширхэг	29	31	1	4%
Пальто	мян.ширхэг	16	20	3	22%
Ээрмэл утас	тонн	191	211	20	10%
АЖИЛТНУУДЫН ТОО	хүн	1,652	1,193	(459)	-28%
Нэг ажилтанд ногдох орлого	мян.төг	149,532	206,360	56,828	38%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	сая.төг	20,354	2,222	(18,133)	-89%
НИЙТ ӨР ТӨЛБӨР	сая.төг	304,820	324,405	19,584	6%
Банкны зээл	сая.төг	228,136	278,048	49,911	22%
НИЙТ ХӨРӨНГӨ	сая.төг	306,277	302,249	(4,029)	-1%
Бараа материал	сая.төг	122,708	124,807	2,098	2%




БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО /тэрбум төгрөг/




ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/



ҮЙЛДВЭРЛЭСЭН ТОО /мянган ширхэг/




БОРЛУУЛСАН ТОО /мянган ширхэг/




2025 онд компани 246.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, өмнөх оны түвшинг тогтвортой хадгалсан байна. Борлуулалтын орлогын бүтцийн хувьд сүлжмэл бүтээгдэхүүн 53%-ийг бүрдүүлж голлох жинг эзэлж байгаа бол нэхмэл бүтээгдэхүүн 19%, оёмол бүтээгдэхүүн 20%, бусад бүтээгдэхүүн 8%-ийг тус тус эзэлж байна. Бүтцийн өөрчлөлтөөс харахад сүлжмэл бүтээгдэхүүний эзлэх хувь буурч, бусад сегментүүдийн оролцоо харьцангуй нэмэгдсэн нь бүтээгдэхүүний багцын төрөлжилт сайжирч байгааг илтгэнэ. Мөн компани 2025 онд 0.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 2024 оны 3.7 тэрбум төгрөгийн алдагдлаас ашигт ажиллагаанд шилжсэн. Энэ нь алдагдлыг 106%-аар бууруулж, үйл ажиллагааны үр ашиг болон зардлын хяналт мэдэгдэхүйц сайжирсныг харуулж байна.


АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



ӨР ТӨЛБӨРИЙН /EBITDA/




МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ /тэрбум төгрөг/




2025 оны нийт маркетингийн зардлыг өмнөх оноос 9% бууруулж 9.6 тэрбум төгрөгийг зарцуулсан. Үүнээс 82%-ийг буюу 7.9 тэрбум төгрөгийг гадаад зах зээл дэх маркетингийн зардал эзэлж байна. Тайлант онд гадаад зах зээлийг идэвхжүүлэх маркетингийн зардлыг өмнөх оноос 10%-аар бууруулсан. Мөн ROAS буюу 1 төгрөгийн дижитал маркетингийн зардлаас олж буй орлогын дүн 3.2 болж өмнөх оны мөн үеэс буурсан нь 2025 оноос брэндиг маркетингийг түлхүү хийн урамшууллын маркетингийг бууруулсантай холбоотой юм.

2025 онд компанийн ашигт ажиллагааны үзүүлэлтүүд 2024 онтой харьцуулахад мэдэгдэхүйц сайжирч, үйл ажиллагааны ашгийн хувь 2 пунктээр, EBITDA маржин 13 пунктээр, цэвэр ашгийн түвшин алдагдлаас ашигт шилжсэн нь үндсэн үйл ажиллагааны ашиг болон зардлын удирдлага сайжирч, эерэг өөрчлөлт гарч байгааг илтгэж байна. Өрийн удирдлага тогтвортой түвшинд хадгалагдаж, Өр/EBITDA харьцаа 5.9 болж сайжирсан нь санхүүгийн чадавх бэхжиж байгааг харуулж байна.


НИЙТ ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/



БАРАА МАТЕРИАЛЫН ЭРГЭЦ /хоног/



МӨНГӨН УРСГАЛ (ШУУД АРГААР) /тэрбум төгрөг/



2025 онд үйл ажиллагаанаас нийт 268.6 тэрбум төгрөг орсон ба 2024 онтой харьцуулахад 2.6% өссөн. Харин гарах мөнгөн урсгалын хувьд нийт 251.1 тэрбум төгрөг зарцуулсан ба үүнээс 91.8 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардалд, 97.0 тэрбум төгрөгийг бэлтгэн нийлүүлэгчдийн төлбөрт, 35.8 тэрбум төгрөгийг татварын зардалд, санхүүжилтийн зардалд 25.9 тэрбум төгрөг тус тус төлсөн. Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ 3.1 тэрбум төгрөг байна.

2025 онд компанийн нийт хөрөнгө 302.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 1 хувиар буурсан нь хөрөнгийн хэмжээ тогтвортой байгааг илтгэж байна. Эздийн өмч -22.2 тэрбум төгрөгт хүрсэн нь хуримтлагдсан алдагдлын нөлөөлөл хэвээр байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч компанийн зүгээс эргэлтийн хөрөнгийн удирдлагыг сайжруулах, ялангуяа түүхий эд, бараа материалын нөөцийг бууруулах чиглэлд бодит арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд бараа материалын эргэлт 353 хоног болж, өмнөх оноос 1%-аар сайжирсан байна. Энэ нь хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлж, мөнгөн урсгалын үр ашгийг сайжруулах эерэг хандлагыг илэрхийлж байна.



САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

Санхүүжүүлэгчийн нэр	Валют	Дуусах хугацаа	2024.12.31		2025.12.31	
			мян.валют	мян.төг	мян.валют	мян.төг
Банкны зээл						
Голомт банк (Урт хугацаат зээл)	MNT	2025	-	3,333,333	-	-
Голомт банк (Урт хугацаат зээл)	MNT	2027	-	-	-	46,400,000
Голомт банк (Зээлийн шугам)	MNT	2028	-	9,300,000	-	5,065,000
Голомт банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	10,400,000	-	-
Хаан банк (Зээлийн шугам)	MNT	2027	-	-	-	100
Хаан банк (Урт хугацаат зээл)	MNT	2027	-	-	-	5,666,660
Хас банк (Зээлийн шугам)	MNT	2029	-	36,210,000	-	40,000,000
Хас банк (Урт хугацаат зээл)	MNT	2027	-	-	-	10,666,667
Хас банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	8,333,333	-	-
Азийн хөгжлийн банк (ADB)	USD	2026	\$ 9,600	32,834,400	\$ 4,800	17,071,968
Азийн хөгжлийн банк (ADB)	USD	2026	\$ 14,400	49,251,600	\$ 7,200	25,607,952
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	2027	€ 14,000	49,937,720	€ 14,000	58,614,080
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	2027	€ 8,000	28,535,840	€ 8,000	33,493,760
EBRD	MNT	2028	-	-	-	35,461,400
Нийт /Банкны зээл/				228,136,227	278,047,587	
Бондын санхүүжилт						
Бонд (Богино хугацаат зээл) *	USD	2025	\$ 3,250	11,115,813	-	
Нийт санхүүжилт				239,252,039	278,047,587	

Монгол банкны ханш /төг/

	2024.12.31	2025.12.31
USD	3,420.25	3,556.66
EUR	3,566.98	4,186.72



ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй.

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Сонирхлын зөрчилтэй болон холбоотой талуудтай хийх хэлцэлд зөвшөөрөл олгох, хяналт тавих процесс

Говь ХК-ийн “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ын дагуу жил бүрийн эхэнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах хэлцэл хийхийг зөвшөөрсөн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт, хэлцлийн төсвийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар баталдаг. Дээрх журмын дагуу батлагдсан жагсаалтад ороогүй этгээдтэй хийх болон батлагдсан төсвөөс хэтэрсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх бүрд тухайлсан тогтоолоор ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн зөвшөөрөл олгодог. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь Компанийн хэмжээнд хийгдэж буй сонирхлын зөрчилтэй хэлцэл нь батлагдсан төсвийн хүрээнд, зах зээлийн үнэ нөхцөлөөр, хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх дээр улирал бүрийн хорооны хурлаараа дамжуулан тогтмол хяналт тавьж ажилладаг. 2025 оны сонирхлын зөрчилтэй хэлцэл: ТУЗ-ийн 2025 оны 03-р сарын 20-ны №07 тоот тогтоолоор тус зөвшөөрлийг олгосон бөгөөд Эрсдэл, аудитын хорооны ээлжит хурлууд дээр гүйцэтгэлтэй танилцан хяналт тавихаас гадна ТУЗ-ийн жилийн эцсийн хурал дээр 2025 оны нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн гүйцэтгэлтэй танилцаж хяналтыг хэрэгжүүлсэн. Говь ХК-ийн нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдүүд болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг энэхүү тайлангийн 22-р хуудаснаас харж танилцах боломжтой.

Огноо	Гэрээ хэлцлийн утга	Үнийн дүн	Гэрээний нөгөө тал	Гэрээний нөхцөл, болзол	Эхлэх огноо	Дуусах огноо	Хэлцэл баталсан
2025.03.20	2025 онд сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийгдэх хэлцэлд зөвшөөрөл олгох	-	Таван Богд Группийн охин компаниуд	Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах, зээлийн шугамын гэрээ байгуулах	2025.01.01	2025.12.31	№07
2025.04.02	Хаан банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	Зээлийн эрхийн хэмжээг 14 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх	Хаан Банк ХК	Таван Богд Холдингс ХХК болон түүний охин компаниудтай хамтарсан зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	2024.12.31	2027.12.31	№13
2025.04.09	Хэвлэх үйлчилгээ авах	11.8 сая төгрөг	Улаанбаатар Принт ХХК	Хэвлэх үйлчилгээ авах	2025.03.01	2025.03.31	№15
2025.04.17	Хаан банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	-	Хаан Банк ХК	Таван Богд Холдингс ХХК болон түүний охин компаниудтай хамтарсан зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	2024.12.31	2027.12.31	№18



Огноо	Гэрээ хэлцлийн утга	Үнийн дүн	Гэрээний нөгөө тал	Гэрээний нөхцөл, болзол	Эхлэх огноо	Дуусах огноо	Хэлцэл баталсан
2025.05.14	Эргэлтийн хөрөнгийн ногоон зээлийн гэрээ байгуулах тухай	6 тэрбум төгрөг	Хаан Банк ХК	Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн ногоон зээл авах	2025.05.14	2027.05.14	№21
2025.06.19	Андеррайтерийн үйлчилгээний гэрээ байгуулах*	400 сая төгрөг	Таван Богд Капитал ҮЦК ХХК	Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх*	2025.06.20	2025.06.30	№27
2025.07.04	Үнэт цаас худалдан авах	32 тэрбум төгрөг	Бета Лизинг ХХК	Үнэт цаас / өрийн хэрэгсэл/ худалдан авах	2025.07.18	2026.02.28	№29
2025.09.09	Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх	-	Таван Богд Холдингс ХХК	Шаардах эрх хэрэгжүүлсэн хувьцааг тогтоолд заасан үнэ, журмын дагуу худалдан авах	2025.09.11	2025.10.23	№39
2025.09.09	Брокерын үйлчилгээ үзүүлэх үнэт цаасны компанийг сонгох	-	Таван Богд Капитал ҮЦК ХХК	Брокерын үйлчилгээ үзүүлэх	2025.09.11	2025.10.23	№40
2025.10.20	Хаан банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	Зээлийн эрхийн хэмжээг 13 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх	Хаан Банк ХК	Таван Богд Холдингс ХХК болон түүний охин компаниудтай хамтарсан зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	2024.12.31	2027.12.31	№48
2025.11.06	Үнэт цаас худалдахыг зөвшөөрөх	19 тэрбум төгрөг	Таван Богд Тек ХХК / хуучнаар Бета Лизинг ХХК/	Үнэт цаас /өрийн хэрэгсэл/-ийг хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдах	2025.11.11	2025.11.11	№49
2025.11.11	Санхүүжилт хийхийг зөвшөөрөх	10 тэрбум төгрөг	Тваан Богд Нура ХХК	Санхүүжилт хийх	2025.11.11	2027.11.11	№50

*Говь ХК нь 2025 оны 6-р сард биржийн бус зах зээлд өрийн хэрэгсэл (бонд) гаргах бэлтгэл ажлын хүрээнд Таван Богд Капитал ҮЦК ХХК-тай андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан ч, тус өрийн хэрэгслийг гаргаагүй тул зөвхөн бондын танилцуулга баримт бичиг боловсруулсан үйлчилгээний хөлс (20 сая төгрөг)-ийг төлсөн.



2025 ОНЫ ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭ БА ҮЛДЭГДЭЛ /мянган төгрөг/

ХОЛБООТОЙ ТАЛ	ХОЛБОО ХАМААРАЛ
Хувьцаа эзэмшигчид Таван Богд Холдингс ХХК Зэргэлдээ охин компаниуд Бусад холбоотой талууд	Дээд шатны хянагч компани Дээд шатны хянагч компанийн охин компаниуд Хараат, хамтарсан компаниуд, үндсэн удирдлагын багийн гишүүдийн хяналтан дор байдаг бусад холбоотой талууд

1.ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудын үлдэгдэл дараах байдалтай байна:

	2024	2025
Холбоотой талуудад өгсөн урьдчилгаа		
Дээд шатны хянагч компани	-	139,975
Зэргэлдээ охин компаниуд	-	10,000,000
Холбоотой талуудаас авах авлага		
Дээд шатны хянагч компани	70,162	2,289
Зэргэлдээ охин компаниуд	-	1,500
Холбоотой талд өгөх өглөг /Богино хугацаат/		
Дээд шатны хянагч компани	25,309,850	-
Зэргэлдээ охин компаниуд	-	10,945
Холбоотой талаас авсан зээл		
Бусад холбоотой талууд	-	5,442,091

Холбоотой талуудын дансны үлдэгдэлд барьцаагүй ба найдваргүй авлагын сан байгуулаагүй.

2.ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Дараах ажил гүйлгээг Группийн толгой компани болох Таван Богд Холдингс ХХК-тай хийсэн байна:

	2024	2025
Дээд шатны хянагч компаниас авсан урьдчилгаа	177,957,846	148,747,327
Дээд шатны хянагч компаниас авсан урьдчилгааны төлбөр	183,297,808	174,057,177
Дээд шатны хянагч компаниас авсан худалдан авалт	1,379,271	1,548,104
Дээд шатны хянагч компанид хийсэн борлуулалт	22,792	19,215
Дээд шатны хянагч компанид төлөх хүүгийн зардал	4,378,356	4,076,648
Дээд шатны хянагч компанид төлсөн хүүгийн зардал	4,378,356	4,076,648

Дараах ажил гүйлгээг Группийн нэгдсэн хяналтад байдаг бусад холбоотой талуудтай хийсэн байна:

	2024	2025
Бусад холбогдох талуудаас авсан санхүүжилт	325,232,000	214,477,000
Бусад холбогдох талуудаас авсан санхүүжилтийн эргэн төлөлт	335,862,000	214,477,000
Бусад холбоотой талуудад өгсөн зээл	-	20,000,000
Бусад холбоотой талуудад өгсөн зээлийн эргэн төлөлт	-	10,000,000
Бусад холбоотой талуудаас авсан худалдан авалт	1,715,066	3,380,448
Бусад холбоотой талд хийсэн борлуулалт	174,981	880,593
Бусад холбоотой талаас авсан түрээсийн орлого	304,733	585,361
Бусад холбоотой талаас авсан хүүгийн орлого	-	1,300,247
Бусад холбоотой талд төлөх хүүгийн зардал	2,575,220	1,210,492
Бусад холбоотой талд төлсөн хүүгийн зардал	2,575,220	1,210,492




Дараах ажил гүйлгээг дээд шатны хянагч компанийн хараат компани болох ХААН банктай хийсэн байна:

	2024	2025
Хаан банкнаас авсан санхүүжилт	148,311,216	118,211,755
Хаан банкнаас авсан санхүүжилтийн эргэн төлөлт	169,011,431	112,544,995
Хаан банканд хийсэн борлуулалт	231,895	1,244,815
Хаан банкинд төлөх хүүгийн зардал	478,232	512,712
Хаан банкинд хүүгийн төлбөр төлөх	531,164	423,145

Бүх холбоотой талын гүйлгээ нь харилцан тохиролцсон нөхцөлөөр хийгдсэн.

3.ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ


• Санхүүжилтийн зардал	2024	2025
Нийт санхүүжилтийн зардал	30,117,480	34,755,789
Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардал	7,431,806	5,799,852
Эзлэх хувь /холбоотой тал/	25%	17%



Говь ХК нь 2025 онд холбоотой талын санхүүжилтийн зардалд 5,799,852 мянган төгрөг төлсөн нь нийт санхүүжилтийн зардлын 17%-ийг эзэлж байна. Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардлын дундаж төгрөгийн хүү нь 14.4% байна.

Жич: Холбоотой тал нь олгосон санхүүжилтэд санхүүгийн харьцаа болон барьцаа хөрөнгө шаарддаггүй.

• Худалдан авалт	2024	2025
Нийт худалдан авалт	94,696,681	92,782,965
Гадаадын худалдан авалт	34,037,838	23,935,336
Дотоодын худалдан авалт	60,658,842	68,847,629
Холбоотой талаас авсан худалдан авалт	2,960,699	4,928,552
Эзлэх хувь/нийт худалдан авалтад холбоотой талын эзлэх хувь/	3.1%	5.3%
Эзлэх хувь/дотоодын худалдан авалтад холбоотой талын эзлэх хувь/	4.9%	7.2%




Говь ХК нь 2025 онд холбоотой талаас авсан худалдан авалтын дүн 4,928,552 мянган төгрөг буюу нийт худалдан авалтад эзлэх хувь 5.3% байна /2024 онд 3.1%/.

Холбоотой талаас авсан худалдан авалт нь зах зээлийн үнээр хийгдсэн.

Жич: Бүх холбоотой талын гүйлгээ нь Говь ХК-ийн “Худалдан авалтын бодлого”, “Захиалга хүлээн авах, худалдан авах, хүлээлгэн өгөх журам”, “Ажил үйлчилгээ худалдан авах журам”, “Сонгон шалгаруулах хорооны журам”-ын дагуу үнийн харьцуулалт судалгааг хийн, сонгон шалгаруулалтын хороогоор орсны үндсэн дээр зах зээлийн үнээр хийгдсэн бөгөөд харилцан давуу байдлыг олгоогүй болно.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

780,112,500

НИЙТ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧИДИЙН ТОО

25,519

/2025.12.31-ний байдлаар/

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Хувьцаа эзэмшигчийн нэр	2024.12.31		2025.12.31	
	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь
Таван Богд Холдингс ХХК	681,267,736	87.33%	682,106,188	87.44%

Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт ороогүй бөгөөд хувь эзэмшил нь 0.11% нэмэгдсэн.

Таван Богд Холдингс ХХК нь Таван Богд Группийн толгой компани юм. Таван Богд Групп нь бизнесийн 8 салбарт, 20 охин компани, 2 хөрөнгө оруулалттай компани, 13,000 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагааны чиглэлүүд:

- 1. Ноолуур
- 2. Автомашин, уул уурхайн тоног төхөөрөмж
- 3. Нийтийн хоол, түргэн хоолны үйлчилгээ
- 4. Банк & санхүү
- 5. Олон улсын худалдаа, үйлдвэрлэл
- 6. Барилга, бүтээн байгуулалт
- 7. Аялал, жуулчлал, зочлох үйлчилгээ
- 8. IT & эрүүл мэндийн үйлчилгээ



НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ



Д/д	Компанийн нэрс	Д/д	Компанийн нэрс
1	Таван Богд Холдингс ХХК	21	Таван Богд Билдинг Саплай ХХК
2	Таван Богд Интернэйшнл ХХК	22	Таван Богд Тэтгэврийн Хуримтлал ХХК
3	Таван Богд Дистрибьюшн ХХК	23	Таван Богд Моторс ХХК
4	Таван Богд ХХК	24	Гэрлүг Виста Сервис ХХК
5	Эйрлинк Монголиа ХХК	25	Таван Богд Нура ХХК
6	Улаанбаатар Гурил ХХК	26	Ти Би Эм Өү ХХК
7	Жуулчин ХХК	27	Таван Богд Автомотив ХХК
8	Жуулчин Дюти Фрий ХК	28	Таван Богд Дилер ХХК
9	Файв Старс Ин Хархорин ХХК	29	Жуулчин Фүүдс ХХК
10	Хаан Палас ХХК	30	Горхийн Чулуу ХХК
11	Сэргэлэн Резорт ХХК	31	Говийн Од Групп ХХК
12	Таван Богд Фүүдс ХХК	32	Таванбогд Констракшн Машинери ХХК
13	Таван Богд Фүүдс Пицца ХХК	33	Таван Богд Ассет Менежмент ХХК
14	Улаанбаатар Принт ХХК	34	Ю Би Пи ХХК
15	Таван Богд Фүүд Сервис ХХК	35	Таван Богд Эстэйт ХХК
16	Таван Богд Проперти ХХК	36	Таван Богд Сервис ХХК
17	Таван Богд Хаус ХХК	37	Таван Богд Тек ХХК
18	Таван Богд Резиденс ХХК	38	Juulchin World Gmbh /ХБНГУ/
19	Таван Богд Финанс ББСБ ХХК	39	Tavan Bogd Nura LLC /Узбекстан/
20	Таван Богд Капитал ҮЦК ХХК	40	Business Area LLC /Узбекстан/

ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Овог, нэр	Иргэний харьяалал	Эзэмшлийн хувь	
			Хувь хүн	Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд
1	Цагаач БААТАРСАЙХАН	Монгол	0.006%	Таван Богд Холдингс ХХК 87.44% Таван Богд ХХК 0.40% Таван Богд Капитал ҮЦК ХХК 0.04%



ДОТООД ЗАХ ЗЭЭЛ




Борлуулсан бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нь задалбал сүлжмэл бүтээгдэхүүн 58%, оёмол бүтээгдэхүүн 4%, нэхмэл бүтээгдэхүүн 32%, бусад бүтээгдэхүүн 6%-ийг тус тус эзэлж байна.

2025 онд дотоодын зах зээлд ноолууран гутлыг олон нэр төрлийн өргөн сонголттойгоор хэрэглэгчдэд хүргэснээс гадна, дулаан хадгалах чадвар өндөр, ус салхины хамгаалалттай, ус нэвтрүүлэхгүй, амьсгалах боломжтой зэрэг олон төрлийн онцлог шийдэлтэйгээр куртка, хантааз, савхин бээлий зэрэг шинэлэг CashmereTech бүтээгдэхүүнүүдийг худалдаанд нэвтрүүлж, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлснээр борлуулалтыг 156% өсгөсөн.






ДОТООД ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ



Говь ХК нь 2024 онд дотоод зах зээлийн 54%-ийг эзэлж байсан бол 2025 онд 66% болж 12%-ийн өсөлт үзүүлсэн.

БОРЛУУЛАЛТЫН БҮТЭЦ



Дотоод зах зээлийн борлуулалтын бүтцийг үнийн дүнгээр нь авч үзвэл жуулчдын борлуулалт 2024 онд 35% эзэлж байсан бол 2025 онд 7%-аар нэмэгдэж 42%-ийг эзэлж байна.

89% ↑

МОНГОЛ УЛСАД ИРСЭН
НИЙТ ЖУУЛЧИД
847 мянган хүн

43% ↑

ХУДАЛДАН АВАЛТ ХИЙСЭН
ЖУУЛЧДЫН САГСНЫ ДУНДАЖ
773 мянган төгрөг

32% ↑

ЖУУЛЧДЫН ХУДАЛДАН
АВАЛТЫН ДҮН
81.1 тэрбум төгрөг

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2025 онд Монгол улсад зочилсон нийт жуулчдын тоо өмнөх оноос 89% өсч 847 мянгад хүрсэн нь Монгол улсын хувьд түүхэн дээд үзүүлэлт байлаа. Монгол улсад зочилсон нийт жуулчдын 10 хүн тутмын нэг нь буюу 106 мянган жуулчин Говь брэндийн дэлгүүрээр үйлчлүүлсэн.

Улмаар жуулчдын худалдан авалтын дүн өмнөх оноос 32% өсч 81.1 тэрбум төгрөгт хүрсэн нь дотоодын нийт борлуулалтын өсөлт 22%-д хүрэхэд нөлөөлсөн бөгөөд гадаадаас Монгол улсад ирж буй жуулчдын тоо компанийн борлуулалтад шууд нөлөөлдөг гэдгийг харуулж байна.


Манай улс 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарлаж байсан бөгөөд 2025 онд 1 сая жуулчин хүлээн авах зорилт дэвшүүлээд байснаас 847 мянган жуулчид ирсэн тул аялал жуулчлалын салбарын хөгжил, өсөлт нь Говь ХК төдийгүй дотоодын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд борлуулалтаа өсгөхөд маш том түлхэц болсон.



Говь ХК-ийн хувьд энэхүү боломжийг ашиглан жуулчдыг татах, тав тухтай үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, бүтээгдэхүүний сонголтыг сайжруулж нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар стандартаа улам сайжруулахад жил бүр анхаарч ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор 2025 оны 3-р сарын 1-нд Чингис Хаан олон улсын нисэх буудлын татваргүй бүсэд 125м2 талбайд салбар дэлгүүрээ нээж 23,274 гадаад дотоодын үйлчлүүлэгчдэд борлуулалт хийсэн.




ГАДААД ЗАХ ЗЭЭЛ




2025 онд гадаад зах зээлд нийт 46.9 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан ба энэ нь өмнөх оноос 44% буурсан үзүүлэлт байв.

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН БОРЛУУЛАЛТЫН БҮТЭЦ



Гадаад зах зээлийг бүтцээр нь аваад үзвэл 53%-ийг экспортын буюу бөөний борлуулалт, 47%-ийг гадаад дахь охин компаниудын борлуулалт буюу онлайн болон биет дэлгүүрийн борлуулалт эзэлж байна.

ЭКСПОРТЫН БОРЛУУЛАЛТ



2025 онд экспортын зах зээлд 27 харилцагчид бүтээгдэхүүнээ нийлүүлж, 24.9 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан нь

өмнөх оноос 57% буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь компанийн бодлогын хүрээнд үйлдвэрийн бүтээмж болон ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор экспортын харилцагчдын тоог бууруулах шийдвэр гаргасантай холбоотой. Тодруулбал, 2024 онтой харьцуулахад харилцагчдын тоог 46%-аар бууруулж, илүү цөөн боловч тогтвортой, стратегийн ач холбогдолтой харилцагчдад бүтээгдэхүүн нийлүүлэх бодлого баримталж ажилласан. Үүний үр дүнд нийлүүлэлтийн бүтэц өөрчлөгдөж, экспортын борлуулалтын нийт дүн өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй гарсан болно.


2025 оны 11-р сард Казахстан улсын Алмата хотын олон улсын нисэх онгоцны буудалд Франчайз дэлгүүр шинээр нээн 2025 оны сүүлийн байдлаар 3 улсын 4 хотод 5 франчайз дэлгүүртэй үйл ажиллагаа явуулж байна.

Франчайз дэлгүүрийн байршил:

1. Япон улс, Токио хот
2. Турк улс, Анкар хот
3. Турк улс, Истанбул хот
4. Турк улс, Истанбул хот
5. Казахстан улс, Алматы хот



ГАДААД БОРЛУУЛАЛТ



ВЕБСАЙТ


- EU**
- www.gobicashmere.com
 - www.gobicashmere.com/DE
 - www.gobicashmere.com/FR
 - www.gobicashmere.com/PL
- UK**
- www.gobicashmere.com/UK
- US**
- www.gobicashmere.com/US
- CN**
- www.gobicashmere.cn

ПЛАТФОРМ

- EU**
- Zalando: /Герман, Австри, Франц, Шведийн зах зээл/
 - OTTO: /Герман зах зээл/
- US**
- Nordstrom
 - Macy's
 - Amazon
- CN**
- TMALL, JD
- KR**
- Coupang
 - Naver

САЛБАР ДЭЛГҮҮР

- Germany
- Berlin
 - Düsseldorf



2025 онд гадаад борлуулалт 22.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байсан нь өмнөх оноос 15% буурсан үзүүлэлт байв. Үүний гол шалтгаан нь бүтээгдэхүүний үндсэн үнийг нэмэгдүүлж, хямдралын хувийг бууруулсан бодлоготой

холбоотой. Тус бодлого нь брэндийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, зах зээлд илүү өндөр үнэлэмжтэй брэндийн байр суурийг бүрдүүлэх зорилготой хэрэгжсэн бөгөөд үүний зэрэгцээ компанийн алдагдлыг бууруулах, ашигт ажиллагааг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ учир борлуулалтын хэмжээ тодорхой хэмжээгээр буурсан хэдий ч урт хугацаанд брэндийн үнэ цэнэ болон санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн стратегийн шийдвэр юм.

Гадаад борлуулалтын зах зээлээ тэлэх зорилгоор 2025 оны 8-р сард БНСУ-д охин компаниа байгуулав. Мөн борлуулалтын суваг хөгжүүлэх ажлын хүрээнд борлуулалтын оргил үеүдэд АНУ-ын зах зээлд Macy's, Amazon гэсэн хоёр шинэ сувагтай хамтран ажиллаж эхэлсэн нь 2025 оны нийт борлуулалтын үр дүнд эерэг нөлөө үзүүлсэн.



БОРЛУУЛАЛТ

Борлуулалтын суваг	Борлуулалт /сая төгрөг/		Өөрчлөлт %	Борлуулалтад эзлэх %
	2024	2025		
Вебсайт	13,496	11,295	-16%	51%
Салбар дэлгүүр	4,112	4,334	5%	20%
Платформ	8,125	6,342	-22%	29%
НИЙТ	25,733	21,971	-15%	100%

Гадаад борлуулалтыг сувгаар нь задлаад үзвэл вебсайтаар хийсэн онлайн борлуулалт 11.3 тэрбум төгрөг буюу нийт борлуулалтын 51%-ийг, Герман улс дахь хоёр салбар дэлгүүрийн борлуулалт 4.3 тэрбум төгрөг буюу нийт борлуулалтын 20%-ийг, харин худалдааны платформуудын борлуулалт 6.3 тэрбум төгрөг буюу нийт борлуулалтын 29%-ийг тус тус эзэлж байна. Үүн дотроо 2025 оны сүүлээр шинээр нэвтрүүлсэн онлайн платформуудаар 231 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн бөгөөд эдгээр сувгууд нь хэрэглэгчдэд танигдах байдал нэмэгдэхийн хэрээр цаашид борлуулалт өсөх боломжтой гэж үзэж байна.

ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зах зээл	CTR			CR			CPA		
	2024	2025	Өөрчлөлт %	2024	2025	Өөрчлөлт %	2024	2025	Өөрчлөлт %
Европ, Хойд Америк, Их Британи	1.79%	2.39%	+34%	1.58%	1.14%	-28%	\$48.41	\$57.18	-16%
Хятад	3.30%	3.50%	+6%	0.72%	0.72%	-14.53%	¥109.40	¥195.40	179%

Үзүүлэлтүүдийн тайлбар

- CTR /click through rate/**
- Нийт сурталчилгаа харсан тооноос хэдэн хувь нь click буюу үйлдэл хийснийг илэрхийлэх хувь
- CR /conversion rate/**
- Нийт веб рүү зочилсон зочлолтын хэдэн хувь нь худалдан авалт хийж буйг илэрхийлэх хувь
- CPA /cost per acquisition/**
- Нэг захиалга хийлгэхэд гаргаж буй дижитал маркетингийн зардал

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



NPDI x GOBI хамтын ажиллагаа

GOBь брэндийн органик хайлтыг сайжруулах зорилгоор үе шаттай арга хэмжээ аван 2024 оноос хамтран ажиллаж байгаа бөгөөд 2025 оноос эхлэн LLM (Large Language Model)-ууд болох ChatGPT, Gemini, AI Overview буюу “том хэлний загвар”-уудын хариулт дээр GOBь брэндийг дурдагдуулах, вэбсайт дээрх мэдээллүүдийг LLM ойлгоход илүү хялбар болгож, системжүүлэх ажлуудыг хамтран хийж байна.



Борлуулалтын суваг хөгжүүлэлт

- 1-р сар 1858 онд үүсгэн байгуулагдсан, 167 жилийн түүхтэй Macy's худалдааны онлайн платформоор бүтээгдэхүүнээ борлуулж эхлэв.
- 10-р сар Amazon платформоор дамжуулан АНУ-ын зах зээлд албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлэв.
- 11-р сар БНСУ-ын томоохон цахим худалдааны платформ болох Coupang-оор дамжуулан Солонгосын зах зээлд албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлэв.
- 12-р сар Naver Shopping платформоор дамжуулан онлайн борлуулалтаа өргөжүүлж, БНСУ-ын хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ шууд хүргэж эхлэв.




ПРОГРАММ ХӨГЖҮҮЛЭЛТ, ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ

Говь ХК нь сүүлийн жилүүдэд компанийн хэмжээнд Product Lifecycle Management (PLM), SAP S/4 HANA Enterprise Resource Management (ERP), INA Manufacturing Execution System (MES), Conveyor Belt (дамжлагын систем) зэрэг томоохон системүүдийг шат дараатай нэвтрүүлэн, үйлдвэрлэл болон үйл ажиллагааны бүхий л түвшинд программ хөгжүүлэлт, дижитал шилжилтийн ажилд томоохон хөрөнгө оруулалтыг хийсэн.

НЭВТРҮҮЛСЭН СИСТЕМҮҮД



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ — СИСТЕМ ТУС БҮР



MES системүүд (Оёмол, Сүлжмэл) нь үйлдвэрлэлийн дамжлага дахь үр ашгийг 50%-аас дээш нэмэгдүүлж, хамгийн өндөр үр дүнг үзүүлсэн байна.



ТАЙЛАН МЭДЭЭ ГАРАХ ХҮРД & ҮР АШИГ

SAP S/4 HANA

48%

- Тайлан бэлтгэх хугацаа **48%** хурдассан.
- Мэдээллийн **нарийвчлал сайжирсан.**
- Excel ашиглалт **-19.3%** буурсан.

MES Оёмол

39%

- Тайлан бэлтгэх хугацаа **39%** хурдассан.
- Гар бүртгэл багасч, **REAL TIME мэдээлэл хянах** боломж бүрдсэн.
- Цаасан дагалдах хэрэгслүүд **-60%** буурсан.

MES Сүлжмэл

20%

- Тайлан бэлтгэх хугацаа **20%** хурдассан.
- Тайлангийн үйл явц оновчтой болж, **шийдвэр гаргалт хурдассан.**
- Ажилтнууд цалингаа **шууд хянах** боломжтой болсон.

ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ҮР ДҮН



Системүүдийг нэвтрүүлснээр үйл ажиллагааны үр ашиг дунджаар 33% сайжирч, цахим шилжилт амжилттай явагдаж байна.



ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ ТЕХНОЛОГИ, БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

CASHMERETECH ИННОВАЦ ШИНГЭСЭН, НООЛУУРЫН ХОЛЬЦТОЙ ШИНЭ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН



2023 оноос CashmereTech Footwear буюу ноолууран гутлыг зах зээлд нэвтрүүлж, 2024–2025 онуудад үргэлжлүүлэн хөгжүүлсэн. Мөн шинэ нэр төрөл болох CashmereTech Outerwear буюу -15-аас -30 градус хүртэл өмсөх боломжтой олон загварын курткуыг зах зээлд шинээр нэвтрүүлж хэрэглэгчдэд хүргэсэн. Цаашид CashmereTech-ийн хүрээнд жилийн бүх улиралд өмсөх боломжтой нэмэлт шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг шат дараатай хөгжүүлэхээр төлөвлөж байна.

CashmereTech Outerwear 2025 Ноолуурын холиотой дүүргэлттэй шинэ нэр төрлийн куртка

Монголын эрс тэс хуурай цаг агаар болон өдөр тутмын амьдралын хэрэглээнд тохирсон ноолууран дүүргэлтийг бүтээх зорилгоор Полистер, Ноос болон Ноолуурын холиотой куртканы дүүргэлт зохион бүтээв.



Ноолуурын хольцтой инновац шингэсэн шинэ төрлийн дүүргэлттэй 8 шинэ загварын куртка зохион бүтээж, зах зээлд гаргасан.

Өдөн дүүргэлттэй, нэг тал нь 100% ноолуурын утастай сүлжмэл, нөгөө тал нь 100% нейлон ус нэвтрүүлэхгүй, амьсгалдаг даавуутай, хоёр талдаа өмсөх боломжтой шинэ нэр төрлийн 2 шинэ загварын хантааз зохион бүтээж, зах зээлд гаргасан.



CashmereTech Footwear 2025 Ноолуурын хольцтой шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн

Ноолуурын хольцтой инновац шингэсэн 11 шинэ загварын гутал зохион бүтээж, зах зээлд гаргасан.





ЗАГВАР, ДИЗАЙНЫ САЙЖРУУЛАЛТ

Тогтвортой үйлдвэрлэлийг дэмжсэн залгаа оёдолгүй 3D загварын хөгжүүлэлт



Говь ХК нь тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор технологийн шинэчлэл болон бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг тасралтгүй хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үүний хүрээнд дотоод болон гадаад зах зээлд өндөр эрэлттэй үндсэн загваруудыг улам боловсронгуй болгож, өмнө нь 2D буюу хавтгай сүлжмэлийн технологиор оёдолтой үйлдвэрлэж байсан загваруудыг 3D буюу залгаа оёдолгүй сүлжих технологид шилжүүлэн хөгжүүлж хэрэглэгчдэд хүрэх бүтээгдэхүүний чанар, үнэ цэнийг улам нэмэгдүүлэхийг зорьж байна.

Энэхүү технологийн шинэчлэл нь бүтээгдэхүүн нь өмсгөлийн хувьд оёдол мэдрэгдэхгүй тав тухтайгаас гадна үйлдвэрлэлийн оёдлын шат дамжлагыг багасган, өртөг зардлыг бууруулахын зэрэгцээ материалын хаягдлыг багасган, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжихэд чухал хувь нэмэр оруулж байна.



НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(мянган төгрөг)

	2024	2025
Хөрөнгө		
<i>Эргэлтийн хөрөнгө</i>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,326,046	2,804,394
Урьдчилгаа төлбөр	3,512,304	3,944,115
Дансны болон бусад авлага	9,404,878	5,490,244
Бараа материал	122,708,175	124,806,536
	139,951,403	137,045,289
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>		
Үндсэн хөрөнгө	146,412,229	134,499,342
Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	2,780,438	3,068,800
Хойшлогдсон татварын хөрөнгө	5,661,214	6,541,951
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	11,472,217	21,093,186
	166,326,098	165,203,279
	306,277,501	302,248,568
Нийт хөрөнгө		
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
<i>Богино хугацаат өр төлбөр</i>		
Дансны болон бусад өглөг	37,867,812	10,930,011
Гэрээний өр төлбөр	2,129,778	2,044,536
Богино хугацаат түрээсийн өглөг	1,103,295	1,404,476
Орлогын албан татварын өглөг	381,026	1,712,320
Богино хугацаат зээл	211,265,887	171,986,397
	252,747,798	188,077,740
<i>Урт хугацаат өр төлбөр</i>		
Урт хугацаат түрээсийн өглөг	1,922,734	1,494,543
Урт хугацаат зээл	36,210,000	115,683,447
Бусад урт хугацаат өглөг	-	1,355,833
Хойшлогдсон татварын өглөг	13,939,844	17,793,063
	52,072,578	136,326,886
	304,820,376	324,404,626
Нийт өр төлбөр		
Эздийн өмч		
Хувьцаат капитал	780,113	780,113
Дахин үнэлгээний нөөц	43,777,386	42,416,645
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(12,119,789)	(35,936,297)
Хуримтлагдсан алдагдал	(30,980,585)	(29,416,519)
	1,457,125	(22,156,058)
Нийт эздийн өмч		
Нийт өр төлбөр ба эздийн өмч	306,277,501	302,248,568



НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

(мянган төгрөг)		
	2024	2025
Борлуулалтын орлого	247,026,317	246,187,537
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(138,552,341)	(127,901,880)
Нийт ашиг	108,473,976	118,285,657
Бусад орлого	3,649,691	22,051,504
Борлуулалт ба түгээлтийн зардал	(53,217,129)	(57,344,113)
Ерөнхий ба удирдлагын зардал	(24,908,151)	(24,507,306)
Бусад зардал	(6,919,419)	-
Үйл ажиллагааны ашиг	27,078,968	58,485,742
Санхүүгийн орлого	4,465,583	1,323,690
Санхүүгийн зардал	(33,118,100)	(54,912,106)
Татварын өмнөх ашиг / (алдагдал)	(1,573,549)	4,897,323
Орлогын албан татварын зардал	(2,083,660)	(4,693,998)
Тайлант жилийн цэвэр ашиг / (алдагдал)	(3,657,209)	203,325
Бусад дэлгэрэнгүй орлого:		
Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжгүй бусад дэлгэрэнгүй орлого:		
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөлөө	32,341,972	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний татварын нөлөө	(8,085,493)	-
Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:		
Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	(1,457,516)	(23,816,508)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	22,798,963	(23,816,508)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого (алдагдал)	19,141,754	(23,613,183)
Нэгж хувьцаанд ногдох ашиг / (алдагдал) - төгрөгөөр	(5)	0.26



НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(мянган төгрөг)					
	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан алдагдал	Нийт
2024 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	20,514,269	(10,662,273)	(28,316,738)	(17,684,629)
Нийт дэлгэрэнгүй орлого:					
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(3,657,209)	(3,657,209)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	24,256,479	(1,457,516)	-	22,798,963
Эздийн өмчтэй холбоотой өөрчлөлт:					
Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн	-	(993,362)	-	993,362	-
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	43,777,386	(12,119,789)	(30,980,585)	1,457,125
2025 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	43,777,386	(12,119,789)	(30,980,585)	1,457,125
Нийт дэлгэрэнгүй орлого:					
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	203,325	203,325
Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	-	(23,816,508)	-	(23,816,508)
Эздийн өмчтэй холбоотой өөрчлөлт:					
Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн	-	(1,360,741)	-	1,360,741	-
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	42,416,645	(35,936,297)	(29,416,521)	(22,156,060)




НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2024	2025
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Тайлант жилийн цэвэр алдагдал	(3,657,209)	203,325
Тохируулгууд:		
Элэгдэл ба хорогдлын зардал	14,554,268	15,224,714
Орлогын албан татварын зардал	2,083,660	4,693,998
Хүүгийн зардал	28,966,791	30,730,295
Хүүгийн орлого	(21,032)	(1,323,690)
Хөнгөлөлттэй зээлийн дискаунтын нөлөө	3,000,620	4,025,494
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,103,637	70,903
Бараа материалын хасагдуулгын зардал (буцаалт), цэвэр	197,117	59,938
Үндсэн хөрөнгө данснаас хассаны (олз) / гарз	60,004	(119,275)
	46,287,856	53,565,702
Өөрчлөлт:		
Дансны болон бусад авлага	(6,518,867)	20,124,871
Урьдчилгаа төлбөр	1,358,657	(219,899)
Бараа материал	19,615,985	(2,158,299)
Дансны ба бусад өглөг	(5,048,402)	(9,049,329)
Гэрээний өр төлбөр	457,354	(85,242)
	56,152,583	62,177,804
Төлсөн орлогын албан татвар	(1,918,219)	(390,222)
Төлсөн хүү	(24,506,337)	(26,291,212)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	29,728,027	35,496,370
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хүлээн авсан хүү	21,032	1,323,690
Үндсэн хөрөнгө борлуулснаас орж ирсэн мөнгө	25,055	174,768
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(15,206,659)	(1,420,385)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	(5,889,178)	(801,195)
Холбоотой талд өгсөн зээл	-	(20,000,000)
Холбоотой талд өгсөн зээлийн эргэн төлөлт	-	10,000,000
	(21,049,750)	(10,723,122)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Авсан зээл (холбоотой талыг оролцуулаад)	1,248,559,876	1,101,012,639
Гаргасан бонд	10,982,346	-
Төлсөн бонд	-	(10,982,345)
Төлсөн зээл (холбоотой талын зээлийг оролцуулаад)	(1,270,804,301)	(1,091,330,190)
Төлсөн түрээсийн төлбөр	(1,098,962)	(1,293,414)
Төлсөн ногдол ашиг	(355)	(291)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(12,361,396)	(2,593,601)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт) / өсөлт	(3,683,119)	22,179,647
Гадаад дахь охин компаниудын гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	(1,457,516)	(23,816,508)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл дэх ханшийн зөрүүний нөлөөлөл	(24,430)	115,209
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,491,111	4,326,046
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,326,046	2,804,394



2. 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮНГЭЭС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХГҮЙ ТУХАЙ

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 2-р сарын 13-ны өдрийн №03 тоот тогтоолын дагуу 2025 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.





НОГДОЛ АШИГ

Манай компани нь дотоодын зах зээлд байр сууриа хадгалах, улмаар зах зээлд эзлэх хувиа өсгөх, гадаад болон онлайн худалдааны зах зээлээ тэлэхийн тулд техник, технологио шинэчлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр чармайн ажиллахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгө оруулалтын өгөөжийг тасралтгүй өсгөж, ногдол ашиг тогтмол тараах бодлогыг баримталдаг.

“Ногдол ашгийн журам”-ын 2-р бүлэгт ногдол ашгийн бодлогыг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

ХОЁР. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

- 2.1. Компанийн ногдол ашгийн бодлого нь Компанийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдсан байна.
- 2.2. Компани хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд байлгах бодлоготой ажиллана.
- 2.3. Компани нь Компанийн тухай хуулийн 47-р зүйл, Компанийн дүрмийн 8.12-д заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна.
- 2.4. Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тухайн санхүүгийн жилийн татварын дараах цэвэр ашгийн хэмжээ, Компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн ТУЗ тогтооно.
- 2.5. Тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд ногдол ашгийн хэмжээг бууруулахгүй байх бодлого баримтална.
- 2.6. Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгоно.
- 2.7. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.



НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

Ногдол ашиг зарласан он	Хувьцааны тоо (ширхэг)	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төгрөг)	Нийт зарласан ногдол ашгийн дүн (төгрөг)	Ногдол ашиг тараалт
1997	7,801,125	153.80	1,199,813,025	2007 он хүртэлх ногдол ашгийг Говь ХК-ийн албан ёсны веб хуудсаар дамжуулан ирүүлсэн ногдол ашгийн хүсэлтийн дагуу шилжүүлж байна.
1998	7,801,125	150.00	1,170,168,750	
1999	7,801,125	166.00	1,294,986,750	
2000	7,801,125	100.00	780,112,500	
2001	7,801,125	20.16	157,270,680	
2002-2004	7,801,125	-	-	
2005	7,801,125	60.00	468,067,500	
2006	7,801,125	60.00	468,067,500	Санхүүгийн үр дүнгээс шалтгаалан ногдол ашиг хуваарилаагүй.
2007-2009	7,801,125	-	-	
2010	7,801,125	100.00	780,112,500	
2011	7,801,125	100.00	780,112,500	
2012	7,801,125	125.00	975,140,625	
2013	7,801,125	130.00	1,014,146,250	
2014	7,801,125	140.00	1,092,157,500	
2015	7,801,125	140.00	1,092,157,500	2010-2018 он хүртэлх ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн харилцдаг үнэт цаасны компаниуд руу 100% тараасан.
2016	7,801,125	200.00	1,560,225,000	
2017	7,801,125	220.00	1,716,247,500	
2018	780,112,500	6.80	5,304,765,000	
2019-2025	780,112,500	-	-	Санхүүгийн үр дүнгээс шалтгаалан ногдол ашиг хуваарилаагүй.

2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 2-р сарын 13-ны өдрийн №03 тоот тогтоолын дагуу 2025 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.



3. ГОВЬ ХК-ИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ӨГӨХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн 2025 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилтыг баталж, компанийн стратеги, санхүүгийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын бодлого, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоонд тогтмол хяналт тавьж, Гүйцэтгэх удирдлагын багт шаардлагатай санал, зөвлөмж, үүрэг чиглэл өгч, компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад анхааран ажилласан.

2025 онд дэлхийн эдийн засгийн өсөлтийн удаашрал, инфляцын үр нөлөө, хэрэглэгчдийн худалдан авалтын зан төлөвийн өөрчлөлт, загварын салбарын өрсөлдөөн нэмэгдэх зэрэг сорилт бүхий зах зээлийн орчинд компани үйл ажиллагаагаа явууллаа. Ийм нөхцөлд компанийн зүгээс зардлын сахилга бат, үр ашигт төвлөрсөн бодлогыг баримталж, үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх, дижитал шилжилтийг хэвшүүлэх, брэндийн үнэ цэнийг өсгөх чиглэлд анхаарч ажилласан болно.

Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны үндсэн зорилтуудын хэрэгжилтийг дүгнэж үзэхэд дараах үр дүн гарсан байна.

Санхүүгийн үр дүнгийн хувьд тайлант хугацаанд нийт 970 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулж, 246.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллан өмнөх оны борлуулалтын түвшинг хадгалсан бөгөөд зардлын удирдлагыг сайжруулах, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, процессын оновчлол хийх чиглэлд онцгойлон анхаарч ажилласан. Эдгээр арга хэмжээний үр дүнд компанийн санхүүгийн үзүүлэлтүүд сайжирч, 2024 онд 3.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол 2025 онд алдагдлын хэмжээг бууруулан 203 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь компанийн үйл ажиллагааны үр ашиг сайжирч, санхүүгийн тогтвортой байдал бэхжиж эхэлснийг илтгэж байна.

Ийнхүү компани сорилттой макро орчинд үйл ажиллагаагаа тогтвортой хадгалж, алдагдлаас ашигт шилжсэн нь бодит ахиц боловч уг гүйцэтгэл нь голчлон зардлын сахилга бат, үйл ажиллагааны оновчлол, дижитал хөрөнгө оруулалтын эхний үр өгөөжид тулгуурласан байна. Иймд энэхүү ашигт ажиллагааны өсөлт нь урт хугацаанд тогтвортой үнэ цэнэ бий болгож чадах эсэх, эсхүл зардал бууруулалтад хэт хамааралтай байгаа эсэхийг цаашид нарийвчлан үнэлэх шаардлагатай гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс үзэж байна.

Өмнөх жилүүдэд **дижитал шилжилтийн хүрээнд** шат дараатай нэвтрүүлсэн PLM, SAP, MES, Conveyor Belt зэрэг үйлдвэрлэл болон бизнесийн удирдлагын системүүдийг 2025 онд илүү цогцоор нь бүрэн ашиглаж эхэлснээр үйл ажиллагааны бодит үр дүн гарч эхэлсэн байна. Тухайлбал, тайлан мэдээ бэлтгэх хугацаа 20-48 хувиар буурч, үйлдвэрлэлийн дамжлагын үр ашиг 50 хувиас дээш нэмэгдэн, бүтээмж 12-15 хувиар өсөж, үйл ажиллагааны үр ашиг дунджаар 33 хувиар сайжирсан байна. Эдгээр системүүд нь компанийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, үйлдвэрлэлийн бүтээмж болон мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтыг мэдэгдэхүйц сайжруулж, үйл ажиллагааг илүү үр ашигтай, ил тод удирдах суурь нөхцөлийг бүрдүүлсэн стратегийн ач холбогдолтой хөрөнгө оруулалт болсон гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс үзэж байна.

Үйлдвэрлэл, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хүрээнд 2025 онд нийт 882 мянган ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлт 94.5 хувьд хүрч өмнөх оноос 1.6 хувиар сайжирсан байна. Мөн ноолуурын хэрэглээний боломжийг тэлж, CashmereTech технологид суурилсан инновац шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг зах зээлд шат дараалан нэвтрүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг өргөжүүлсэн. Түүнчлэн олон улсын OEKO-TEX STANDARD 100 гэрчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлж, 22 нэр төрлийн сүлжмэл, оёмол, нэхмэл бэлэн бүтээгдэхүүнийг хамруулсан байна.

Дизайны чиглэлд Итали улсын дизайнер Giorgio Spina болон Англи улсын дизайнер Sara Jowett нар ерөнхий дизайнераар ажиллаж, дэлхийн загварын чиг хандлагыг ноолуурын онцлог, шинэ сүлжээстэй хослуулсан шинэлэг коллекцуудыг хэрэглэгчдэд хүргэсэн.

Борлуулалтын зах зээлийн хувьд дотоод борлуулалтын сувгийг өргөжүүлэн Чингис Хаан олон улсын нисэх буудалд шинэ салбараа нээж, үнэнч хэрэглэгчдэд зориулсан урамшууллын хөтөлбөрийг идэвхжүүлэн хэрэгжүүлсэн. Гадаад зах зээлийг тэлэх зорилгоор БНСУ-д охин компани байгуулж, АНУ болон БНСУ-ын зах зээлд Masy's, Amazon, Coupang, Naver зэрэг цахим худалдааны алдартай платформуудаар дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн байна. Мөн маркетингийн үйл ажиллагаанд брэндийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, органик өсөлтийг дэмжих, ашигт ажиллагааг сайжруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэн ажилласан байна.



Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд байгаль орчин, нийгмийн хариуцлага, засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа үе шаттай хэрэгжүүлж, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, нөөцийн үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнээс онцлон дурдвал, үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх байгууламжийг MBBR технологид суурилсан бүрэн автомат системтэйгээр ашиглалтад оруулж, бохир усыг байгаль орчинд аюулгүйгээр цэвэрлэн дахин ашиглах боломжийг бүрдүүлсэн нь компанийн байгаль орчны хариуцлагыг бэхжүүлэх чухал алхам болсон гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс үзэж байна.

Хүний нөөц, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд компанийн хэмжээнд цалингийн систем, ажлын байрны зэрэглэл, цалингийн сүлжээг шинэчилж, ажилтнуудын сэтгэл ханамж, ажлын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Мөн Говь академийн хүрээнд давхардсан тоогоор 4,200 гаруй ажилтан дотоод сургалт хамрагдсан байна.

2025 онд компанийн зохион байгуулалтын бүтцийг илүү цомхон, үр бүтээмжтэй, уялдаа холбоотой болгох зорилгоор Гүйцэтгэх удирдлагын түвшинд хэд хэдэн удаагийн өөрчлөлтийг хийж, санхүү удирдлага, мэдээлэл технологи, хоол үйлдвэрлэл, дотоод аудит зэрэг чиг үүргүүдийг толгой компанийн холбогдох чиг үүргийн компаниудад нэгтгэн шилжүүлсэн. Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс эдгээр өөрчлөлтөд хяналт тавьж, дотоод хяналтын тогтолцооны хараат бус байдлыг хангах, Говь ХК-ийн эрх ашгийг нэн тэргүүнд хангах чиглэлд анхаарч Гүйцэтгэх удирдлагын багийг чиглүүлж ажилласан болно.

Иймд Говь ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын баг нь тайлант хугацаанд батлагдсан төлөвлөгөө, зорилт, шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллаж, компанийн үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах, алдагдлыг бууруулж ашигтай ажиллагааг сэргээх, стратегийн шинэчлэлүүдийг хэрэгжүүлэхэд бодит үр дүнд хүрсэн гэж **Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.**

Дараагийн шатанд компани нь үр ашигт төвлөрсөн гүйцэтгэлээс стратегид суурилсан, урт хугацааны тогтвортой өсөлт болон үнэ цэнийг бий болгохыг зорин, капиталын өгөөж, мөнгөн урсгалын тогтвортой байдлыг сайжруулах, олон улсын зах зээл дэх байр суурийг тодорхойлон бэхжүүлэх, дижитал болон инновацид суурилсан хөгжил, тогтвортой хөгжлийн бодлогыг бизнесийн стратегитай уялдуулан хэрэгжүүлэх чиглэлд онцгойлон анхаарах шаардлагатай гэж үзэж байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь дээрх чиглэлүүдийг тууштай дэмжин, хэрэгжилтэд хяналт тавин ажиллах болно.

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



4. ТУЗ-ИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



Д.ГЭРЭЛМАА

Нэр дэвшүүлэх
хорооны дарга,
Эрсдэл, аудитын
хорооны гишүүн

МЭРГЭЖИЛ
Эдийн засагч

БОЛОВСРОЛ
1982-1988
ЗХУ, Москва хотын Цахилгаан Холбооны Дээд Сургууль, Холбооны инженер эдийн засагч, бакалавр
2000-2003
МУ-ын ЗГ-ийн хэрэгжүүлэгч агентлаг “Удирдлагын академи”, удирдахуйн ухааны доктор

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
1988-1992
Радио Телевизийн Техникийн Төв, эдийн засагч
1992-1994
Эдийн Засгийн Хөгжлийн Коллеж, Бизнес удирдлагын тэнхим, Багш
1994-2003
Эдийн Засгийн Хөгжлийн Коллеж, Бизнес удирдлагын тэнхим, Тэнхимийн эрхлэгч
2003-2006
Монгол Улсаас НҮБ-д суух Байнгын төлөөлөгчийн газар, Швейцарийн Холбооны улс дахь ЭСЯ, Нягтлан бодогч
2006-2009
СЭЗИС, Сургалт Эрдэм Шинжилгээ эрхэлсэн дэд захирал
2009-2015
СЭЗИС, Сургалт эрхэлсэн дэд захирал
2015-2022
СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессор
2022-2024
СЭЗИС, Ахисан Түвшний сургуулийн профессор
2024 оноос
СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессор
2013 оноос
Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн

ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ
Хувьцаа эзэмшдэггүй.



Д.ХҮРЭЛБААТАР

Цалин, урамшууллын
хорооны дарга,
Нэр дэвшүүлэх
хорооны гишүүн

МЭРГЭЖИЛ
Нягтлан бодогч, Эдийн засагч, Санхүүч

БОЛОВСРОЛ
1979-1981
Худалдааны Техникум, Нягтлан бодогч, бакалавр
1985-1989
ОХУ-ын Байгалийн Улсын Их сургууль (Иркутск хотын УАААДС), Эдийн засагч, санхүүч магистр

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
1981-1984
Улсын банк, Улсын байцаагч аудитор
1990-2005
Худалдаа Хөгжлийн Банк, Харилцагчийн үйлчилгээний газрын захирал
2005-2007
Монгол шуудан банк, Дэд захирал
2008-2016
Говь ХК, ТУЗ-ийн гишүүн
2007-2020
Худалдаа Хөгжлийн Банк, Гүйцэтгэх захирлын орлогч
2020-2022
Худалдаа Хөгжлийн Банк, ТУЗ-ийн ажлын албаны дарга
2022 оноос
Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн

ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ
4,800 ширхэг (0.0006%)



А.ЖАРГАЛМАА

Эрсдэл, аудитын
хорооны дарга,
Цалин урамшууллын
хорооны гишүүн

МЭРГЭЖИЛ
Нягтлан бодогч

БОЛОВСРОЛ
2008-2012
Oxford Brookes Их Сургууль, Нягтлан бодох бүртгэл, бакалавр
2010-2012
ACCA Мэргэшлийн түвшний шалгалтууд, (Association of Chartered Certified Accountants)
2012-2015
Санхүү Эдийн Засгийн Их сургууль, Бизнесийн удирдлага, магистр
2013-2015
Хандонг Глобал Их Сургууль, Глобал менежмент, MBA

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
2012-2017
Багш, Санхүү Эдийн Засгийн их сургууль
2013-2014
Итезмон ХХК, Нягтлан бодогч
2014-2014
Иаруди Консалтинг ХХК, Зөвлөх
2016-2018
Бурый мэдвэдь ХХК, Нягтлан бодогч
2015-оноос
Дүнгээ ХХК, Нягтлан бодогч
2017 оноос
GAPE (Global Academy for Professional Education), ACCA ахлах багш, хөтөлбөрийн удирдагч
2019 оноос
Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн

ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ
Хувьцаа эзэмшдэггүй.

ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮД



Ц.БААТАРСАЙХАН

ТУЗ-ийн дарга

МЭРГЭЖИЛ
Инженер

БОЛОВСРОЛ
1984-1988
Монгол улс, Политехникийн Их Сургууль, Холбооны инженер, бакалавр
1989-1993
Япон улс, Токио хотын Цахилгаан Холбоо, Электроникийн Их Сургууль, Электроникийн инженер, бакалавр

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
1993-1997
Япон Монголын хамтарсан Алтай ХХК, Гүйцэтгэх захирал
1999-2000
Жуулчин ХХК, Ерөнхий захирал
2000-2001
Палас зочид буудал, Гүйцэтгэх захирал
2001-2003
МИАТ ТӨХК, Дэд ерөнхийлөгч
2008-2024
Говь ХК, Гүйцэтгэх захирал
1997 оноос
Таван Богд Холдингс ХХК, Ерөнхий захирал
2003 оноос
Таван Богд Групп, Ерөнхийлөгч
2009 оноос
Хаан Банк ХК, ТУЗ-ийн гишүүн
2007 оноос
Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ
Хувь хүн: 50,000 ширхэг (0.006%)
Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:
Таван Богд Холдингс ХХК 682,106,188 ширхэг (87.44%)
Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)
Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



Д.ХУЛАН

Нэр дэвшүүлэх
хорооны гишүүн

МЭРГЭЖИЛ

Олон улсын банк санхүү

БОЛОВСРОЛ

1985-1990

Орос улс, Москвагийн Санхүүгийн Дээд Сургууль, Олон улсын банк санхүү, бакалавр

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1990-1992

Монгол Улсын Сангийн Яам, Эдийн засгийн гадаад харилцааны хэлтэс, Эдийн засагч

1993-1997

Говь ХК, Токио дахь салбар, Төлөөлөгч, худалдааны менежер

1997-2000

Таван Богд Холдингс ХХК, Дэд захирал

2000-2002

Худалдаа Хөгжлийн Банк, Дэд захирал

2003-2021

Таван Богд Групп, Тэргүүн дэд ерөнхийлөгч

2003-2021

Хаан Банк ХК, ТУЗ-ийн гишүүн

2009 оноос

Люксембург улсын Монгол дахь өргөмжит консул

2021 оноос

Хаан Банк ХК, ТУЗ-ийн дэд дарга

2021 оноос

Таван Богд Групп, ТУЗ-ийн дарга

2007 оноос

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ

Хувь хүн: 12,973,022 ширхэг (1.66%)

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 682,106,188 ширхэг (87.44%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



Ц.ОРГИЛБОЛД

Говь Кашмер Европ
ХХК-ийн Гүйцэтгэх
захирал

МЭРГЭЖИЛ

Олон улсын харилцаа

БОЛОВСРОЛ

2011-2014

Япон улс, Temple Их Сургууль, Олон улсын харилцаа, бакалавр

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2014

Эдийн засгийн хөгжлийн яам, Чөлөөт бүс хариуцсан мэргэжилтэн

2016

Таван Богд Холдингс ХХК, Бизнес хөгжлийн менежер

2016-2017

Жуулчин Дютри Фрий ХК, Гүйцэтгэх захирал

2017-2019

Гоёо ХХК, Гүйцэтгэх захирал

2019-2021

Говь ХК, Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал

2021-2022

Саппорт Сервисес Монголиа ХХК, Дэд захирал

2022-2023

Говь ХК, Тэргүүн дэд захирал /Дизайн, үйлдвэрлэл, дэмжих/

2023-2025

Говь ХК, Тэргүүн дэд захирал /Гадаад, экспортын борлуулалт/

2023 оноос

Говь Кашмер Европ ХХК, Гүйцэтгэх захирал

2023 оноос

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ

Хувь хүн: Хувьцаа эзэмшдэггүй.

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 682,106,188 ширхэг (87.44%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



Б.АМАРСАЙХАН

Говь ХК-ийн
Гүйцэтгэх захирал

МЭРГЭЖИЛ

Бизнесийн удирдлага ба энтерпренершип

БОЛОВСРОЛ

2016 - 2019

Их Британи улс, Westminster Их Сургууль, Бизнесийн удирдлага ба энтерпренершип, бакалавр

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2019-2023

Говь Кашмер Европ ХХК, Гүйцэтгэх захирал

2022-2024

Говь ХК, Стратеги, өсөлт хөгжил хариуцсан захирал

2022 оноос

Таван Богд Холдингс ХХК, Стратеги, бизнес хөгжил хариуцсан захирал

2022 оноос

Говь Кашмер Их Британи ХХК, Гүйцэтгэх захирал

2023 оноос

Говь Кашмер Казахстан ХХК, Говь Кашмер Америк ХХК, Говь Кашмер Өвөр Монгол ХХК, Гүйцэтгэх захирал

2024 оноос

Говь ХК, Гоёо ХХК, Гүйцэтгэх захирал, Говь Австрали салбарын захирал

2023 оноос

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ

Хувь хүн: 1,000 ширхэг (0.0001%)

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 682,106,188 ширхэг (87.44%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



Б.ЦЭЭНЯМ

Эрсдэл, аудитын
хорооны гишүүн

МЭРГЭЖИЛ

Маркетингийн менежмент

БОЛОВСРОЛ

2014-2018

Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Маркетингийн менежмент, бакалавр

2022-2023

АНУ, Lindenwood Их Сургууль, Бизнесийн удирдлага, магистр

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2018-2021

Таван Богд Холдингс ХХК, Маркетингийн газар, Судалгааны менежер

2023-2025

АНУ, Anand Resource компани, Ерөнхий менежер

2025-2025

Таван Богд Холдингс ХХК, Дотоод аудит хариуцсан дэд захирал

2025 оны

12-р сараас Ар И Ди Эженси ХХК, Гүйцэтгэх захирал

2024 оноос

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ

Хувь хүн: Хувьцаа эзэмшдэггүй.

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 682,106,188 ширхэг (87.44%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



Б.ОРГИЛ

Цалин урамшууллын
хорооны гишүүн

МЭРГЭЖИЛ

Санхүүгийн удирдлага

БОЛОВСРОЛ

2006-2011

Бүгд Найрамдах Турк Улс, Bogazici University, Олон улсын худалдаа, санхүү, бакалавр

2012-2015

Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Санхүүгийн менежмент магистр
CFA Level 2 тэнцсэн

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2011-2012

СББ Трейд ХХК, Мэргэжилтэн

2012-2013

Эрдэнэс Оюу Толгой ХХК, Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн

2013-2018

Монголын Төмөр Зам ТӨХК, Эдийн засгийн албаны менежер

2018-2022

Иргэний Нисэхийн Ерөнхий Газар, Эдийн засгийн зохицуулалтын тасгийн дарга

2022-2025

Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК, Зөвлөх

2025 оноос

Таван Богд Холдингс ХХК, Санхүү удирдлага хариуцсан захирал

2025 оноос

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ

Хувь хүн: Хувьцаа эзэмшдэггүй.

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 682,106,188 ширхэг (87.44%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)

ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

- ТУЗ-ийн даргаар ажиллаж байсан Д.Гэрэлмаа нь өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасантай холбоотой 2025 оны 2-р сарын 1-ний өдрөөс эхлэн ТУЗ-ийн даргаар Ц.Баатарсайханыг томилсон.
- 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатай сонгон томилов. Б.Оргил, Б.Цээням гишүүд ТУЗ-ийн ердийн гишүүнээр шинээр сонгогдсон.

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ, ТОМИЛОХ

Говь ХК нь компанийн дүрэмдээ заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал хураах кумулятив аргаар сонгон 3 жилийн хугацаатай томилдог.

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зүгээс ТУЗ-ийн гишүүдийн идэвх оролцоо, ажлын тайлан, гүйцэтгэлтэй танилцан, компанийн урт хугацааны стратеги төлөвлөлт, бизнесийн чиг хандлагатай уялдуулан ТУЗ-ийн гишүүдийг улираан нэр дэвшүүлэх, эсхүл бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах эсэх шийдвэрийг хэлэлцэн гаргадаг.

Говь ХК-ийн “ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам”-ын дагуу Нэр дэвшүүлэх хорооны зүгээс ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж шийдвэрлэсэн тохиолдолд ердийн болон хараат бус гишүүдийн тоо, шинээр нэр дэвшүүлэх хараат бус гишүүдийн хэрэгцээ, мэргэжил, ур чадварын нэмэлт шалгуурыг тодорхойлон, сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг. Хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг нээлттэй байдлаар, эсвэл өмнөх сонгон шалгаруулалтад оролцсон нэр дэвшигчдээс сонгон шалгаруулах гэсэн арга хэлбэрээс сонгон явуулдаг. Улмаар нэр дэвшигчдэд үнэлгээ хийн, хэлэлцэн, дүгнэлт гаргасны үндсэн дээр нэр дэвшигчдийн жагсаалтыг батлан гаргадаг.

Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгох хүртэл ТУЗ-ийн шийдвэрээр түр томилж, хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурлаар оруулж батлуулдаг. Түр томилогдсон гишүүн нь хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан байх ба ТУЗ-ийн гишүүний бүх эрх, үүргийг эдэлнэ.



ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооноос тодорхойлон санал боловсруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг. Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин сар бүр олгох тогтмол цалин болон хурлын оролцоонд үндэслэсэн цалин гэсэн бүтэцтэй байдаг. 2024 оны 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг дараах байдлаар тогтоосон. 2025 онд цалингийн хэмжээнд өөрчлөлт ороогүй.

ТОГТМОЛ ЦАЛИН		ОРОЛЦООНД ҮНДЭСЛЭСЭН НЭМЭЛТ ЦАЛИН
Ердийн гишүүний үндсэн цалин	Хараат бус гишүүний үндсэн цалин	ТУЗ-ийн хурал, Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон оролцоо тутамд 650,000₮
1,400,000₮	2,800,000₮	
ТУЗ-ийн даргын албан тушаалын нэмэгдэл 1,000,000₮		
ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга нарын албан тушаалын нэмэгдэл 400,000₮		

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ЗАРЧИМ

Цалин, урамшууллын хорооны 2024 оны эхний хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалин, хангамж, урамшууллын зарчмыг дараах байдлаар тодорхойлсон.

- ТУЗ-ийн гишүүд нь компанийн санхүү, үр дүнгээс хамаарсан аливаа урамшуулал авахгүй.
- ТУЗ-ийн хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг үнэлэх зорилгоор хараат бус гишүүдийн үндсэн цалинг ердийн гишүүдийнхээс өндөр байлгана.
- Компанийн Менежмент багт ажилладаг ТУЗ-ийн ердийн гишүүд нь ТУЗ-ийн гишүүний хувьд аливаа хангамжийг давхар авахгүй.

ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Хурал	Ээлжит хурал	Ээлжит бус хурал	Цахим санал хураалт	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал зөвлөмж	Үүрэг даалгавар	Баталсан тогтоол
ТУЗ-ийн хурал	2	3	21	57	62	6	4	53
Хараат бус гишүүдийн хурал	1	-	-	7	5	-	-	-
Эрсдэл, аудитын хорооны хурал	3	-	3	24	11	12	8	4
Нэр дэвшүүлэх хорооны хурал	1	2	4	15	14	4	12	8
Цалин, урамшууллын хорооны хурал	1	-	-	6	7	2	1	1
Нийт	8	5	28	109	99	24	25	66

Говь ХК-ийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2025 онд нийт 8 ээлжит хурал, 5 ээлжит бус хурал, 28 цахим санал хураалт зохион байгуулж гишүүд идэвх санаачилгатай ажиллан нийт 109 асуудлыг хэлэлцэн, 99 шийдвэр гаргаж, 66 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 24 санал зөвлөмж, 25 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилт дээр нь хяналт тавьж анхаарч ажиллав. ТУЗ-ийн шийдвэрийн биелэлт 97%, удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлт 83% хэрэгжилттэй байв.



ХУРЛЫН ИРЦ

№	ТУЗ-ийн гишүүний нэр	ТУЗ-ийн хорооны харьяалал	ТУЗ-ийн хурлын ирц	ТУЗ-ийн хорооны хурлын ирц
1	Д.Гэрэлмаа	Нэр дэвшүүлэх хорооны дарга, Эрсдэл, аудитын хорооны гишүүн	100%	100%
2	Д.Хүрэлбаатар	Цалин, урамшууллын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	100%	100%
3	А.Жаргалмаа	Эрсдэл, аудитын хорооны дарга, Цалин, урамшууллын хорооны гишүүн	100%	100%
4	Ц.Баатарсайхан	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн /2025 оны 5-р сар хүртэл/	100%	100%
5	Д.Хулан	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн, Цалин, урамшууллын хорооны гишүүн /2025 оны 5-р сар хүртэл/	100%	100%
6	Б.Цээням	Эрсдэл, аудитын хорооны гишүүн, Цалин, урамшууллын хорооны гишүүн /2025 оны 5-р сар хүртэл/	100%	75%
7	Б.Оргил	Цалин, урамшууллын хорооны гишүүн	100%	100%
8	Б.Амарсайхан	-	85%	-
9	Ц.Оргилболд	-	100%	-

Хурлын давтамж

Ээлжит хурал: ТУЗ-ийн хурал улиралд нэг удаа буюу жилд 4 удаа, Хараат бус гишүүдийн хурал жилд 1 удаа, Эрсдэл, аудитын хорооны хурал улиралд нэг удаа буюу жилд 4 удаа, Нэр дэвшүүлэх хорооны хурал хагас жилд нэг удаа буюу жилд 2 удаа, Цалин, урамшууллын хорооны хурал хагас жилд нэг удаа буюу жилд 2 удаа хуралддаг.

Ээлжит бус хурал: ТУЗ болон хороодын ээлжит бус хурлыг ТУЗ-ийн дарга, гишүүд, компанийн Гүйцэтгэх захирал болон Менежмент багийн гишүүдийн санаачилга, шаардлагаар хэдийд ч хуралдуулж болно.



2025 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Говь ХК-ийн ТУЗ нь 2025 онд 2 ээлжит хурал, 3 ээлжит бус хурал, 21 удаагийн цахим санал хураалт зохион байгуулж, нийт 57 асуудал хэлэлцэж, 62 шийдвэр гаргав. Мөн чиг үүргийнхээ хүрээнд 6 төрлийн санал зөвлөмж, 4 үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтнуудад өгч, хяналт тавьж ажилласан бөгөөд 53 тогтоол батлав. Тайлант хугацаанд ТУЗ-ийн шийдвэрийн биелэлт 99%, удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт 100% байв.

2025 онд ТУЗ-ийн зүгээс компанийн санхүү, үйл ажиллагаанд хяналт тавих, стратегийн чиглэл өгөх үндсэн чиг үүргийнхээ хүрээнд тогтмол, системтэй ажиллав. Оны эхний хурлаар компанийн бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, цаашид сар бүр санхүү, үр дүнгийн тайлангаар дамжуулан төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавин, шаардлагатай зөвлөмж, чиглэлийг удирдлагын багт өгч ажилласан.

Компанийн засаглалыг сайжруулах, дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх зорилтын хүрээнд 3-р сард Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж, хууль тогтоомж болон олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн хэрэгжилтийг хангах чиглэлээр анхаарч ажилласан.

Говь ХК нь байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын асуудлуудад онцгой ач холбогдол өгч ирсэн бөгөөд ТУЗ энэ чиглэлд хяналт, удирдлагын үүргээ тууштай хэрэгжүүлсэн. Тухайлбал, 4-р сарын ээлжит хурлаар БОНЗ-ын үйл ажиллагааны тайлантай танилцаж, ТУЗ-өөс баталсан тогтвортой хөгжлийн үүрэг амлалтын хэрэгжилтэд дүгнэлт хийж, удирдлагын багийг цаашдын үйл ажиллагаанд үр дүнтэйгээр чиглүүлэн ажилласан.

ТУЗ-ийн үндсэн үүргийн нэг болох хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн эрх ашиг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд оны эхний хурлаар 2025 онд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх боломжтой холбоотой талуудын жагсаалт, хэлцлийн төсвийг баталж, батлагдсан төсөвт тусгагдаагүй сонирхлын зөрчилтэй хэлцлийг тухай бүр хурлаар хэлэлцэн зөвшөөрөл олгож, Эрсдэл, аудитын хороогоор дамжуулан хяналтыг хэрэгжүүлэн ажилласан.

Мөн энэ оны төлөвлөгөөнд тусгагдаагүй ч онцгой ач холбогдолтой асуудлын хүрээнд 7-р сард компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) болох асуудлыг хэлэлцэхээр шийдвэрлэж, 2025 оны 9-р сарын 8-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулсан. Тус хурлаар ХХК болох саналыг оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99.99 хувийн саналаар дэмжин баталсан.

Энэхүү шийдвэртэй холбогдуулан Компанийн тухай хууль болон Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн “хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх”-ийг хэрэгжүүлэх нөхцөл үүссэнтэй холбоотойгоор ТУЗ-өөс холбогдох шийдвэр болон журмыг баталсан.

Оны сүүлийн хурал дээр компанид нэвтрүүлсэн томоохон системүүд болох SAP S/4 HANA ERP, MES(Manufacturing Execution System) болон Conveyor Belt (Дамжлагын систем)-ийн системийн хэрэгжилт, үр дүнтэй танилцан хяналт тавьж ажилласан.



КОМПАНИЙН ХЭЛБЭР ӨӨРЧЛӨХ ПРОЦЕСС (ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШИЙДВЭР ГАРГАСАН ТУХАЙ)

Говь ХК-ийн 2025 оны 9-р сарын 8-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн хэлбэрийг ХХК болгон өөрчлөх шийдвэр гарсантай холбогдуулан Компанийн тухай хуулийн 53, 54, 55 дугаар зүйл, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 23.4.3, 23.4.5, 23.5, 23.6, 23.9-д заасныг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн “Хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх” (шаардах эрх)-ийг холбогдох хууль, журамд заасны дагуу зохион байгуулахыг Т УЗ-д даалгасан.

ТУЗ-ийн 2025 оны 9-р сарын 9-ний өдрийн №39 тоот тогтоолоор шаардах эрхийг хэрэгжүүлэх шийдвэр гарган, түүнтэй холбоотой журмыг баталж, эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийг тогтоосон. Мөн тус тогтоолд заасан үнэ, журмын дагуу шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлтээ ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авахыг компанийн хяналтын багцын хувьцааг эзэмшигч “Таван Богд Холдингс” ХХК-д зөвшөөрсөн.

Энэхүү шаардах эрхийг хэрэгжүүлэх шийдвэр нь Говь ХК-ийн зүгээс санаачилсан үйл ажиллагаа биш бөгөөд дээр дурдсан хууль болон журмын дагуу бусад хувьцаа эзэмшигчдэд хуулиар олгогдсон эрхийг хангаж буй үйл ажиллагаа юм.

Хувьцаа эзэмшигчдээс өөрийн эзэмшлийн хувьцааг худалдаж авахыг компаниас шаардах хүсэлт, эсхүл компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хуулийн дагуу ажлын 30 хоногийн хугацаанд буюу 2025 оны 9-р сарын 11-ний өдрөөс 2025 оны 10-р сарын 23-ны өдрийг дуустал хүлээн авч Хувьцаа эзэмшигчдийн хурлаас батлагдсан төсөл болон журмын хэрэгжилтийг ханган ажилласан.

Компанийн хэлбэр өөрчлөх процесстэй холбоотой эрх бүхий байгууллагын дүгнэлт, зөвшөөрлийн шатны үйл явц үргэлжилж байгаатай холбоотойгоор шаардах эрхийг хэрэгжүүлэх ажиллагаа зохицуулалтын процесс бүрэн дуусах хүртэл түр хойшлогдоод байна. Энэ хугацаанд Говь ХК-ийн хувьцаа Монголын хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагдсан хэвээр байна.

Шаардах эрхийг хэрэгжүүлэх хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцаанд аливаа хязгаарлалт тогтоогдоогүй бөгөөд тэдгээрийг зах зээл дээр чөлөөтэй арилжаалах боломж нээлттэй хэвээр байгаа болно.



ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ТАЙЛАН

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

Зорилго

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь ТУЗ-ийг Эрх бүхий албан тушаалтнууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад Менежмент багийн удирдлагуудын залгамж халааны тогтвортой байдлыг хангах, тэдгээрийн ажил үүргийн тодорхойлолт, гэрээний нөхцөлийг тодорхойлох, ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч хяналт тавин, чиг удирдлагаар хангах гэсэн үндсэн чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино. Мөн тус хороо нь ЭБАТ-уудтай холбоотой шүгэл үлээх системээр ирүүлсэн мэдээллийг шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Бүрэлдэхүүн

Бүрэлдэхүүн	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	ТУЗ-ийн гишүүний нэр
Хорооны дарга	Хараат бус гишүүн	Д.Гэрэлмаа
Гишүүд	Хараат бус гишүүн	Д.Хүрэлбаатар
	Ердийн гишүүн	Д.Хулан

Хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт:

- ТУЗ-ийн 2025.05.14-ны №20 тоот тогтоолоор тус хорооны гишүүн Ц.Баатарсайханы оронд ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хуланг томилов.

2025 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Нэр дэвшүүлэх хороо нь 2025 онд хорооны үйл ажиллагааны журам, холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, 1 ээлжит хурал, 2 ээлжит бус хурал, 4 удаагийн цахим санал хураалт зохион байгуулж 15 асуудлыг хэлэлцэн, 14 шийдвэр гаргав. Хорооны зүгээс 4 төрлийн санал зөвлөмж, 12 үүрэг даалгаврыг холбогдох удирдлага, албан тушаалтнуудад өгч, хяналт тавьж ажилласан бөгөөд 8 тогтоол батлав. Тус хорооны шийдвэрийн биелэлт 100%, удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлт 100% хэрэгжилттэй байв.

Компанийн ЭБАТ-уудын залгамж халааны тогтвортой байдлыг хангах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс албан бичгээр ирүүлсэн “ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид санал оруулах тухай” хүсэлтийг хүлээн авч, “ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу нэр дэвшигчдийг тодорхойлон, 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатай сонгон томилуулав.

ЭБАТ-уудын ажил үүргийн тодорхойлолт, гэрээний нөхцөлийг тодорхойлон хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Оны эхний ээлжит хурал дээр ЭБАТ болон Менежмент багийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах талаар Гүйцэтгэх захирлаас санал оруулсан өөрчлөлтийн төслүүдийг хэлэлцэн, үндэслэлтэй гэж үзэн дэмжсэн.
- 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн дүрмийг шинэчлэн батлуулах үед ЭБАТ-уудын бүрэлдэхүүнд өөрчлөлтийг тусган батлуулсан.
- Менежмент багийн удирдлагуудын бүтэц бүрэлдэхүүн, чиг үүргийн үр дүнтэй байдалд хяналт тавьж ажилласан.

ЭБАТ-уудын ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч хяналт тавин, удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:



- Оны эхний хурлаар Гүйцэтгэх захирлын ажлын тайлантай танилцаж, үйл ажиллагааны үр дүнг дүгнэн, цаашид баримтлах чиглэл, чиг үүргийн зөвлөмжүүдийг өгч ажилласан.
- Тус хурал дээр Менежмент багийн удирдлагуудын 2024 оны ажлын үр дүнд Гүйцэтгэх захирлаас өгсөн дүгнэлттэй танилцан, цаашид үйл ажиллагааг сайжруулах санал зөвлөмжийг өгөв.
- Менежмент багийнхны жилийн тайлан болон гүйцэтгэлд үндэслэн хамт олноо манлайлан удирдаж, амжилттай ажилласан хоёр удирдлагыг ТУЗ-ийн нэрэмжит шагналд нэр дэвшүүлэн, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шагнасан.
- Хорооны үйл ажиллагааны журамд заасны дагуу компанийн шүгэл үлээх системээр ЭБАТ-уудтай холбоотой ирсэн мэдээллийг тухай бүр шийдвэрлэн холбогдох удирдлагуудад санал зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавруудыг өгч хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.
- ТУЗ-ийн өөрийн үнэлгээ болон ТУЗ-ийн гишүүний өөрийн үнэлгээний асуулгыг шинэчлэн баталсан.



ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

Зорилго

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь ТУЗ-ийг Эрх бүхий албан тушаалтнууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад Менежмент багийн удирдлагуудыг цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, Компанийн хэмжээнд баримтлах Цалин, урамшууллын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Бүрэлдэхүүн	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	ТУЗ-ийн гишүүний нэр
Хорооны дарга	Хараат бус гишүүн	Д.Хүрэлбаатар
Гишүүд	Хараат бус гишүүн	А.Жаргалмаа
	Ердийн гишүүн	Б.Оргил

Хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт:

ТУЗ-ийн 2025.05.14-ны №20 тоот тогтоолоор тус хорооны гишүүн Д.Хулангийн оронд ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Оргилыг томилов.

2025 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Цалин урамшууллын хороо нь 2025 онд үйл ажиллагааны журам, холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд 1 ээлжит хурал зохион байгуулж, 6 асуудлыг хэлэлцэн, 7 шийдвэр гаргав. Хорооны зүгээс 2 төрлийн санал зөвлөмж, 1 үүрэг даалгаврыг холбогдох удирдлага, албан тушаалтнуудад өгч, хяналт тавьж ажилласан бөгөөд 1 тогтоол батлав. Тус хорооны шийдвэрийн биелэлт 100% байв.

ЭБАТ-уудын цалин, урамшууллын бодлогыг тодорхойлон, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Оны эхний хурлаар Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын зарчмыг хэлэлцэн батлав.
- ТУЗ-ийн гишүүдийн цалингийн гүйцэтгэлтэй танилцаж, 2025 оны цалингийн төсвийг боловсруулан 4-р сард зохион байгуулагдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нээлттэй хэлэлцүүлж батлуулсан.
- ЭБАТ-уудын цалин урамшууллын гүйцэтгэлтэй танилцаж хяналт тавихын зэрэгцээ 2025 онд ЭБАТ-уудад олгох урамшууллын дээд хязгаарыг тогтоов.
- Мөн салбарын жишиг, зах зээлийн нөхцөл болон амьжиргааны доод түвшинтэй уялдуулан компанийн хэмжээнд мөрдөх цалингийн доод хэмжээг хэлэлцэн тодорхойлсон.

Компанийн хэмжээнд баримтлах цалин, урамшууллын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тодорхойлон, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийнхээ хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Оны эхний хурлаар компанийн 2024 оны цалин, урамшууллын гүйцэтгэлд дүгнэлт хийж, 2025 оны төсвийг хэлэлцэн бизнес төлөвлөгөөнд тусган ТУЗ-өөр батлуулсан.
- Тус хурлаар мөн байгууллагын соёлын судалгааны үр дүнтэй танилцаж удирдлагад санал зөвлөмжийг өгсөн.
- Компанийн цалин, урамшууллын тогтолцоо, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдтэй танилцах, түүний үр дүнтэй байдалд хяналт тавьж, чиг удирдлагаар ханган ажилласан.



ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРОО

Зорилго

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавих, чиглүүлэх, дотоод хяналт, комплайнс болон эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавих, чиглүүлэх, хараат бус аудитын байгууллагатай харилцан, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжоор хангах гэсэн үндсэн 3 чиг үүргийг хэрэгжүүлж ТУЗ-ийг эрсдэлийн удирдлага болон компанийн үйл ажиллагаа дахь хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Бүрэлдэхүүн	ТУЗ-ийн гишүүний хэлбэр	ТУЗ-ийн гишүүний нэр
Хорооны дарга	Хараат бус гишүүн	А.Жаргалмаа
Гишүүд	Хараат бус гишүүн	Д.Гэрэлмаа
	Ердийн гишүүн	Б.Цээням

Хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт:

- 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотой ТУЗ-ийн 2025.05.14-ны №20 тоот тогтоолоор тус хорооны гишүүн Н.Мөнхбатын оронд ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Цээнямыг томилон.

2025 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Эрсдэл, аудитын хороо нь 2025 онд хорооны үйл ажиллагааны журам болон холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд идэвхтэй ажиллаж, 3 ээлжит хурал, 3 удаагийн цахим санал хураалтыг зохион байгуулан нийт 24 асуудал хэлэлцэж, 11 шийдвэр гаргасан. Мөн 4 тогтоол баталж, 12 төрлийн санал, зөвлөмж, 8 үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтнуудад өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Тайлант хугацаанд хорооны шийдвэрийн хэрэгжилт 82%, удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт 63% байна. Оны сүүлийн хагас жилд компанийн хэлбэрийг өөрчлөх шийдвэр гарч, уг шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулалтын болон үйл ажиллагааны тодорхой өөрчлөлтүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Мөн компанийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн сайжруулах, давхардсан чиг үүргийг нэгтгэх, шилжүүлэх зэрэг өөрчлөлтүүд хийгдсэн зэрэг шалтгаанаар зарим шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилт хугацааны хувьд хойшлогдох нөхцөл үүссэн. Эдгээр шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахаар төлөвлөж байна.

Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны хяналтын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- 1-р сарын ээлжит хурлаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн шинэчилсэн төслийг хэлэлцэж, хорооны санал, зөвлөмжийг тусган 3-р сард ТУЗ-өөр батлуулсан.
- Компанийн улирал болон хагас жилийн санхүүгийн тайлангуудтай танилцан дүгнэж, олон нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.
- Улирал бүрийн хурлаар дамжуулан сонирхлын зөрчилтэй болон холбоотой талуудтай хийгдсэн гүйлгээний гүйцэтгэлтэй танилцан ТУЗ-ийн 2025.03.20-ны №07 тогтоолоор баталсан холбоотой талуудтай хийх гүйлгээний төсвийн хэрэгжилтэд хяналт тавив.
- Компанийн хэмжээнд санхүү, татвар болон үйл ажиллагааны бусад чиглэлээр хийсэн шалгалтын дүгнэлт, материалтай танилцах, тэдгээрт илэрсэн зөрчлийг арилгах талаар удирдлагад үүрэг даалгавар санал зөвлөмжийг өгч ажилласан.

Компанийн дотоод хяналт, комплайнс, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Дотоод аудитын хэлтсийн ажлын тайлантай улирал бүр танилцаж компанийн хэмжээнд хийгдсэн дотоод аудитын ажлын үр дүнтэй танилцан дотоод хяналтын чиг үүргээ хэрэгжүүлсэн.



- Дотоод аудитын дүрмийн шинэчилсэн төслийг хэлэлцэн, сайжруулалтын саналууд өгч шинэчлэн баталсан.
- 1-р улирлын ээлжит хурал дээр Комплайнсын газрын үйл ажиллагааны тайлантай танилцаж үйл ажиллагааг төлөвшүүлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх талаар санал зөвлөмж өгсөн. Мөн тус хурлаар Комплайнсын удирдлагын үйл ажиллагааны журмын шинэчилсэн төслийг хэлэлцэж, сайжруулах санал гаргав.
- Хагас жилийн ээлжит хурлаар эрсдэлийн удирдлагын багийн ажлын тайлан, эрсдэлийн үнэлгээний үр дүнтэй танилцаж цаашид авах арга хэмжээний талаар удирдамж өгсөн. Түүнчлэн “Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх түвшний баримт бичиг”-тэй танилцан санал зөвлөмж хүргүүлсэн.
- Мөн тус хурал дээр Мэдээлэл технологийн газрын тайлантай танилцаж компанийн хэмжээнд нэвтрүүлэн хэрэгжүүлж буй шинэ системүүдийн хэрэгжилт, үр нөлөөнд хяналт тавьж ажилласан.

Хараат бус аудитын байгууллагатай харилцах, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжоор хангах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Оны эхний хурал дээр 2024 хараат бус аудиторын дүгнэлт зөвлөмжтэй танилцаж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.
- 2024 оны тусдаа буюу охин компаниуд ороогүй санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагын сонгон шалгаруулалтын материалтай танилцан санал өгч ТУЗ-ийн 2025.06.19-ний №24 тоот тогтоолоор аудитын байгууллагыг сонгов.
- 2025 оны хөндлөнгийн аудиторын сонгон шалгаруулалтад хорооны гишүүдийн зүгээс хараат бус байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийж, үнийн саналтай танилцан санал өгч ТУЗ-ийн 2025.09.17-ны №44 тоот тогтоолоор аудитын байгууллагыг сонгов.
- 11-р сард 2025 оны хөндлөнгийн аудитын төлөвлөгөөтэй и-мэйлээр танилцсан бөгөөд оны сүүлийн хурал дээр аудитын үйл ажиллагааны явцтай танилцсан.

5. ТУЗ-ИЙН 2026 ОНЫ ЦАЛИНГИЙН ТӨСӨВ

/төгрөг/

Агуулга	2025 он			2026 он		
	Төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэл %	Төсөв	2025Т/2024Т өөрчлөлт	Өөрчлөлт %
Тогтмол цалин	237,200,000	233,600,000	-2%	228,000,000	(9,200,000)	-4%
Оролцооны цалин	59,150,000	31,850,000	-46%	46,800,000	(12,350,000)	-21%
НДШ	32,598,500	26,461,213	-19%	31,602,000	(996,500)	-3%
Нийт цалин	328,948,500	291,911,213	-11%	306,402,000	(22,546,500)	-7%



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ
ТОГТООЛЫН ТӨСӨЛ

Төсөл

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4-р сарын 29-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны
тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.9.10 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн 2025 оны санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2026 оны 4-р сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Говь ХК-ийн 2025 оны санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралт 1-ээр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Төсөл

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4-р сарын 29-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
цалингийн төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.9.12 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2026 оны 4-р сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны цалингийн төсвийг дараах байдлаар баталсугай.

Агуулга	2025 он		2026 он	
	Төсөв	Төсөв	Өөрчлөлт	
			төгрөг	хувь
Тогтмол цалин	237,200,000	228,000,000	(9,200,000)	-4%
Оролцооны цалин	59,150,000	46,800,000	(12,350,000)	-21%
НДШ	32,598,500	31,602,000	(996,500)	-3%
Нийт цалин	328,948,500	306,402,000	(22,546,500)	-7%


2. Батлагдсан төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Цалин, урамшууллын хороонд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны 03-р сарын 18-ны өдрийн хурлын
10-р тогтоолын 7-р заалт



**ГОВЬ ХК-ИЙН 2026 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС**

Комиссын дарга	Нягтлан бодогч	Б.Урангоо
Комиссын гишүүд	Нягтлан бодогч	Ц.Амарзаяа
	Нягтлан бодогч	Б.Номин
	Нягтлан бодогч	Б.Ууганзаяа
	Тогтвортой хөгжлийн ахлах менежер	А.Гомбосүрэн
	Тогтвортой хөгжлийн мэргэжилтэн	Н.Чинсэтгэл



САНАЛ АВАХ ХУУДАСНЫ ЗАГВАР

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны 03-р сарын 18-ны өдрийн хурлын
10-р тогтоолын 3-р заалт



GOBI

**"ГОВЬ" ХК-ИЙН 2026 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС**

Хурлын өдөр: 2026 оны 4-р сарын 29-ний өдөр
Эхлэх цаг: 14:00 цаг
Байршил: **ГОВЬ ХК-ийн өөрийн байр**
(Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК-ийн өөрийн
байр, 1-р дөхөр, Сургалтын танхим)

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ:

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:	
Иргэний бүртгэлийн дугаар: /Хуулийн этгээдийн хувьд регистрийн дугаар/	
Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо:	
Утасны дугаар:	
И-мэйл хаяг:	

САНАЛ ХУРААХ АРГА: ЭНГИЙН АРГА

№	Шийдвэр гаргаж, батлах асуудал	Хурлаас гаргах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1	Компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах	ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай	☐	☐	☐	
2	ТУЗ-ийн 2026 оны цалингийн төсвийг батлах	2026 оны цалингийн төсвийг батлах тухай	☐	☐	☐	

Огноо: 2026 оны ... -р сарын ... -ны өдөр

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг

Санал өгөх заавар:

- Саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож (✓ **эсвэл** +) тэмдэг тавина.
Жишээ нь: зөвшөөрсөн бол "Зөвшөөрсөн" гэсэн нүдэнд (✓ **эсвэл** +), татгалзсан бол
"Татгалзсан" гэсэн нүдэнд (✓ **эсвэл** +), түдгэлзсэн бол "Түдгэлзсэн" гэсэн нүдэнд (✓ **эсвэл** +)
тэмдэг тавина.
- Хэрэв татгалзсан бол "Таны өгөх санал" гэсэн нүдэнд уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх саналтай
байгаагаа бичнэ.
- Хүчингүй саналын хуудас:** Засварласан, балласан, (✓ **эсвэл** +)-ээс өөр тэмдэглэгээ
хэрэглэсэн, нэгээс олон санал бөглөсөн болон аль нэг саналыг бөглөөгүй саналын хуудсыг
хүчингүйд тооцно.



"ГОВЬ" ХК,
ҮЙЛДВЭРИЙН ГУДАМЖ, 3-Р ХОРОО, ХАН-УУЛ ДҮҮРЭГ,
УЛААНБААТАР-17062, МОНГОЛ УЛС, Ш/Х 36/434

УТАС: +976 7013-9977, ФАКС: +976 7014-3081
И-МЭЙЛ: INFO@GOBI.MN